



"ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ"
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

ТҮҮХЭН ШИЙДВЭР:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг Улсын Их Хурал баталлаа.

*Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан.
2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр*





МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМ




БАЯЛАГ БҮТЭЭГЧИЙН
ДЭМЖИХ ХОЛБОО



ГАЗАР ТАРИАЛАН



ХҮНС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР



МАЛ АЖ АХУЙ



Монгол Улсын Ерөнхийлөгч хүнсний хангамж, аюулгүй байдалд онцгой анхаарч, 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг хуралдуулж, зөвлөмж гарган, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд дэлгэрэнгүй мэдээлэл хийж, улс орон даяар **"ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ" эхлүүлсэн.**



ХҮНСНИЙ ХАНГАМЖ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ БАЙНА

ИМПОРТЫН ХАМААРАЛ 48.0%

**2021 онд хүнсний импорт
1 ТЭРБУМ ОРЧИМ АМ.ДОЛЛАР**

№	Бүтээгдэхүүн	2021
1	Загас	100%
2	Төрөл бүрийн будаа	100%
3	Элсэн чихэр	100%
4	Ургамлын тос	100%
5	Тахианы мах	99%
6	Жимс, жимсгэнэ	98%
7	Хүнсний давс	97%
8	Сүү /хуурай/	82%
9	Цөцгийн тос	67%
10	Өндөг	49%
11	Хүнсний ногоо	38%
12	Сүүн бүтээгдэхүүн	41%
13	Гурилан бүтээгдэхүүн	33%
14	Гурил	1%
15	Мах	0%
16	Төмс	0%



Тэрбээр хэлэхдээ

"Монгол төрийн бодлогын цөмд монгол хүн, монгол өрх байж ирсэн, цаашид ч байх учиртай.

Үндэсний аюулгүй байдал нь монгол хүн бүрийн аюулгүй байдалтай шууд холбоотой.

Хүнээ хамгаалъя, хүнээ хөгжүүлбэ гэвэл хүнсээ сайжруулах ёстой.

Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх суурь асуудлын нэг нь хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх явдал юм.

Хүнс эрүүл байвал монгол хүн эрүүл байна. Монгол хүн эрүүл байвал Монгол үндэстэн хүчирхэг байна.

Тиймээс Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамж, иргэдийн эрүүл зөв амьдрал, хүний бие махбодын хэрэгцээ шаардлагад нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нь онцгой чухал байна.

Эзэн богд Чингис хаан нэгэнтээ "Чи бусдын хийсэн хоолыг идэж, бусдын хийсэн хувцсыг өмссөн тэр цагт бусдын боол болсон хэмээн бодоорой" гэж айлдсан гэдэг.

Бидний өвөг дээдэс өнө эртнээс нүүдлийн мал аж ахуй эрхэлж хоол хүнс, дээл хувцас, эд зүйлсээ өөрсдөө үйлдвэрлэж, худалдаа наймаа эрхэлж, бусдаас хараат бус оршин тогтнож ирсэн олон зуун жилийн түүхтэй.

Социализмын үеийн он жилүүдэд ч аж үйлдвэрийн хөгжил эрчимжиж мах, гурил, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо зэрэг олон төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангаж ирсэн төдийгүй 1985 онд "Хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтот программ"-ыг дэвшүүлэн хэрэгжүүлж байсан.

Өвөг дээдсийн сургаал, түүхэн туршлагаас харахад бид монгол хүнсээр дотоодын хэрэгцээгээ хангаж, үндэсний аюулгүй байдлаа баталгаажуулж ирснийг илтгэж байна.



Чадгар байсан зүйлээ чадахгүй болно гэдэг хөгжил, дэвшлээс ухарсан хэрэг юм. Үүнд л бид анхаарлаа хандуулж, алдаагаа засах учиртай”

Өнөөдөр дэлхий дахинд үүсээд буй нөхцөл байдал, цар тахал, тээвэр логистикийн хүндрэл, ажилгүйдэл, ядуурал, бараа бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт зэргээс шалтгаалсан хүнсний хангамж, аюулгүй байдлын асуудал улс орон бүрийн нэн тулгамдсан сорилт боллоо.

Энэ нь цаашлаад дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн зорилтод томоохон эрсдэл учруулж байна.

Өнөөдөр дэлхийн зах зээл дээр хүнс болон бордооны үнэ сүүлийн 14 жилийн хугацаанд байгаагүй хамгийн өндөр хувиар өсөөд байна. Ялангуяа, үр тариа, ургамлын тосны үнэ сүүлийн саруудад огцом өсөж, бага орлоготой иргэдийн амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулж байна.

Сүүлийн 15 сарын хугацаанд хөдөө аж, ахуйн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр 43 хувиар, түүний дотор үр тарианы үнэ 56 хувиар өслөө. Сүүлийн гуравхан сарын хугацаанд бордооны үнэ 20 хувиар өссөн байна.



НҮБ-ын судалгаагаар 2021 оны байдлаар дэлхийн 53 орны 193 сая хүн ам хүнсний аюулгүй байдлын эрсдэлд орсон нь 2020 онтой харьцуулахад ганцхан жилийн дотор 40 сая хүнээр өссөн гүн гарчээ. Нөхцөл байдал энэ онд ч улам дордох төлөвтэй байгааг олон улсын байгууллагууд анхааруулж байна”

Хүнсний гол экспортлогч улс болох манай хоёр хөрш ОХУ, БНХАУ хүн амынхаа хүнсний хангамж, аюулгүй байдалдаа ихээхэн анхаарч байна. Тухайлбал, иргэдийн амьжиргаа, хүн амын өсөлт, насжилт, геополитикийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан БНХАУ-ын дотоодын хүнсний хангамжийн түвшин 2030 он хүртэл буурах эрсдэлтэй байгааг олон улсын байгууллагуудын судалгаа харуулж байна.

Манай улстай эдийн засгийн бүтцээрээ ижил төстэй гэгддэг Казахстан Улс гурил, үр тариа, мах, сүүн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг хэдий ч цаашид дотоодын хүнсний хангамж, аюулгүй байдалдаа онцгой анхаарч үр тариа, гурилын экспортоо хязгаарласан мэдээ байна.

Мөн дэлхийн томоохон үйлдвэрлэгч орны нэг болох Турк Улсад сүүлийн 20 жилд байгаагүй ихээр инфляц өсөж 70 хувьд хүрлээ. Энэ огцом өсөлтөд хүнс болон тээврийн үнийн өсөлт голлон нөлөөлжээ.

Манай стратегийн түнш улс болох Япон, Солонгос, Энэтхэг зэрэг улс ч хүнсний хангамж, аюулгүй байдалдаа онцгойлон анхаарч эхэллээ.

Ийнхүү дэлхий нийтээр хүнсний хангамж, аюулгүй байдал эрсдэлд орж байгаа учраас өнгөрсөн 04 дүгээр сарын 13-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллага, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Дэлхийн худалдааны байгууллага хамтарсан уриалга гаргаж, дэлхий нийтээрээ үүнд онцгой анхаарч, олон улсын хамтын ажиллагааг улам эрчимжүүлэхийг санууллаа.

Эрхэм төрийн түшээд ээ,

Өнөөдөр манай улс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ бараг тэн хагасыг, түүн дотроо хүнсний бүтээгдэхүүнийхээ 50 орчим хувийг гаднаас авч байна. Өнгөрсөн 2021 онд л гэхэд нэг тэрбум ам.доллараар хэмжигдэх хүнсний бүтээгдэхүүнийг импортоор худалдан авчээ.

Монголчууд бид мах, гурил, төмс гэсэн гурван бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж байна. Энэ бол чамлахааргүй амжилт бөгөөд олон жилийн нөр их хөдөлмөр юм.

Алийн болгон бид айлаас давсаа хүртэл гуйж амьдрах вэ.

Ганцхан жишээ дурдахад л олон зуун жилийн нүүдлийн мал аж ахуйн соёлтой, 70-аад сая малтай, сүү, сүүн бүтээгдэхүүнээрээ дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах нөөц бололцоотой манай улс өнөөдөр импортын хуурай сүүгээр хийсэн сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэж байна.

Түүн дотроо нялх нярай, бага насны хүүхдүүд эх орондоо үйлдвэрлэсэн шим тэжээлтэй сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэж чадахгүй байна.

Энэ манай улсын хүнсний үйлдвэрлэл, хангамжийн эмзэг байдал нь дэлхий нийтийг хамарсан цар тахал, олон улсын түвшинд үүсээд буй геополитикийн нөхцөл байдлын улмаас улам ихээр мэдрэгдэх боллоо.

Тухайлбал, манай улсын хүнсний бүтээгдэхүүний үнэ сүүлийн нэг жилийн хугацаанд 20 орчим хувиар огцом өсөж, инфляц 15 хувьд хүрч ард иргэдийн амьжиргаа, улс орны эдийн засагт хүндээр тусаж байна.

Цаашид ч дэлхий нийтийн хүнсний хангамж, нийлүүлэлтийн доголдол хэдий хүртэл үргэлжлэх нь тодорхойгүй байгаа бөгөөд энэ нь манайх шиг хөгжиж буй улсын хүнсний хангамж, аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй байна.

Мөн хүнсний хангамж, нийлүүлэлтээс гадна хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал ч манай улсын үндэсний аюулгүй байдлын тулгамдсан асуудал болоод байна.

Хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн хангасан бүтээгдэхүүн хэрэглэдэг болохын тулд шат шатандаа хяналтаа чангатгаж, стандартаа мөрдүүлж, хүний эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдалд харшилсан аливаа үйлдэлтэй хатуу тэмцэх ёстой.

Тухайлбал, хорт хавдрын нас баралтаараа манай улс дэлхийд тэргүүлж, чанаргүй хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт их байгаа нь манай орны хүнсний чанар, аюулгүй байдалд аюулын харанга дэлдсэнийг харуулж байна.

Мөн НҮБ-ын судалгаагаар манай улсын хүн амын 20 орчим хувь нь хангалттай хэмжээний шим тэжээлтэй хүнсээр хангагдаж чадахгүй байгааг онцолжээ.



Гэхдээ гурилан бүтээгдэхүүний 33, хүнсний ногоо болон сүүн бүтээгдэхүүний 40 орчим, өндөгний 50 орчим хувь, загас, будаа, элсэн чихрээ 100 хувь, тахианы мах, ургамлын тос, бүр хүнсний давсаа хүртэл 100 хувь гаднаас авч байна”



Үйлдвэрлэж, импортолж, экспортолж, борлуулж байгаа бүх хүнсний бүтээгдэхүүн эрүүл, чанартай байх ёстой. Итгэмжлэгдсэн лабораториудын хүчин чадал хангалтгүй, хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн шинжилж чадахгүй байгаа нь манай улс хүнсний аюулгүй байдлаа бүрэн хянаж чадахгүй байгааг харуулж байна”



2022.05.13 - Төрийн ордон



Бид цаашид улс орныхоо эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, түүн дотроо тогтвортой хөгжлийн хамгийн гол үзүүлэлт болох хүнсний хангамж, аюулгүй байдлыг эрс сайжруулахад урд урдынхаас илүү анхаарч, ихээхэн хүчин чармайлт гарган ажиллах шаардлагатай байна”



Өөрөөр хэлбэл, манай улсын хөдөө аж ахуйн салбар нь эрүүл малтай, өндөр бүтээмжтэй, байгаль орчинд ээлтэй, суурь дэд бүтэцтэй, санхүү, даатгалын оновчтой тогтолцоотой, шинэ техник, технологийг нэвтрүүлсэн, мэргэшсэн хүний нөөцтэй, хувийн хэвшилд тулгуурласан байх хэрэгтэй”

Энэ нь хүнсний хангамжаас гадна ажилгүйдэл, ядуурал, өрхийн орлоготой ч шууд холбоотой юм.

Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хүнсний хангамж, аюулгүй байдал-Газар тариалан” үндэсний чуулганыг өнгөрсөн сард зохион байгуулж, чуулганаас гаргасан зөвлөмжийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн.

Төрийн тэргүүн Улсын Их Хурлын чуулганд үндэсний аюулгүй байдал, улс орны гадаад болон дотоод нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлаар хоёр удаа хаалттай мэдээлэл хийсэн.

Мөн өнгөрсөн долоо хоногт Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг хуралдуулж, хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай зөвлөмж гаргалаа.

Үүнд та бүхэн анхаарлаа хандуулж, судалж үзсэн гэдэгт итгэж байна.

Эрхэм нөхөд өө,

Өнгөрсөн 30 жилд хөдөө аж ахуйн салбарт төрийн зүгээс үзүүлсэн дэмжлэг тийм ч бага байгаагүй. Харин бодит үр дүн, ахиц дэвшил ямар байгааг та бүхэн дор бүрнээ тунгаан бодож, эргэцүүлэн дүгнэх нь зүйтэй.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээний үнэлгээгээр “Хүнсний аюулгүй байдлын холбогдох заалтууд хангалттай хэрэгжээгүй” гэж дүгнэсэн байна.

Энэ дүгнэлтээс үзэхэд нэн тэргүүнд төрийн бүх шатны байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, нэгдсэн зохион байгуулалтыг сайжруулж, дор бүрнээ эрхэлсэн ажилдаа эзэн байж, сахилга, хариуцлагаа эрс чангатгахыг хатуу сануулж байна.

Орчин үеийн хөдөө аж ахуйн салбар нь олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай, аливаа эрсдэлд дархлаатай, өрхийн үйлдвэрлэлээс улс үндэстний үйлдвэрлэл хүртэл хүртээмжтэй, засаглал, санхүүжилтийн оновчтой тогтолцоотой байх ёстой.

Ийм учраас Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн дагуу Улсын Их Хурал, Засгийн газар хүнсний хангамж, аюулгүй байдлыг онцгойлон анхаарч, тусгайлан хэлэлцэхийг санал болгож, тогтоолын төсөл өргөн барьж байгаа бөгөөд Засгийн газраас хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг Улсын Их Хуралд яаралтай горимоор оруулан, хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Монголчууд бид ирэх таван жилд гол нэрийн 19 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, Хүнсний хувьсгал хийцгээе.

Өөрөөр хэлбэл, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, лууван, байцаа, манжин, сонгино, саримс, хүрэн манжин, гурил, гурилан бүтээгдэхүүн, хүлэмжийн ногоо, өндөг, цөцгийн тос, хүнсний давс, тахианы мах, ургамлын тосоор хүн амын хүнсний хэрэгцээг дотоодоосоо бүрэн хангаж, цаашдаа элсэн чихэр, төрөл бүрийн будаа, гахайн мах, жимс, жимсгэнээр хангах ажлыг эрчимтэй эхлүүлэе.

Үүний тулд "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг орон даяар өрнүүлэх санаачилга дэвшүүлж байна.

Энэ хүрээнд дараах суурь шинэчлэлүүдийг хийхэд анхаарах шаардлагатай байна.

Үүнд:

1. Монгол хүнсээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, хүнс экспортлогч улс болоход шаардлагатай эрх зүйн шинэчлэл хийж, Хүнс, хөдөө аж ахуйн тухай багц хуулийг батлан гаргах;
2. Хөдөө аж ахуйн кластеруудыг хөгжүүлэх, хүнсний үйлдвэрлэлийн цогцолборууд байгуулах, түүхий эд боловсруулах, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо болон тээвэр логистикийн оновчтой сүлжээ хөгжүүлэх;
3. Тариалангийн талбайг хашаажуулж, ойн зурвас байгуулж, эрчимжсэн газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх, хүн амыг хүнсний ногоогоор жилийн дөрвөн улирлын турш тогтвортой хангах хүлэмжийн цогцолбор, зоорины аж ахуйг нэмэгдүүлэх;
4. Стандартын шаардлага хангасан хүнсний улаан буудайн стратегийн байнгын нөөц бүрдүүлдэг болох, хүнсний аюулгүй байдал, хяналт, баталгаажуулалтыг боловсронгуй болгон итгэмжлэгдсэн лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлж, хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн шинжилдэг болгох;
5. Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх стратегийг



сайжруулж, био бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэн ойрын таван жилийн хугацаанд малын өвчингүй эрүүл бүс болох;

6. Суурь дэд бүтэц болох ус, усалгаа, эрчим хүч, уур, дулааны найдвартай эх үүсвэрийг хангах, усны нөөцийг зөв зохистой ашиглах, усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх;
7. Шинэ техник, технологи, инновац нэвтрүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин, мэргэшсэн ажилчдыг үе шаттай бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах орчныг бүрдүүлэх;
8. Төсөв, санхүүгийн нөөц боломжоо бүрэн дүүрэн, үр дүнтэй ашиглаж, зах зээлийн зарчимд суурилсан татвар, даатгалын оновчтой, хүртээмжтэй тогтолцоо бий болгон, эргэлтийн хөрөнгийн болон урт хугацааны хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл, санхүүжилт, урамшуулал олгох, мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг түлхүү ашиглах;
9. Тариалангийн зориулалттай газрын хэмжээг тэлэх, нэмэгдүүлэх, хөрсний доройтлыг бууруулах, ээлжлэн тариалалтын техник, технологийн шинэчлэл хийх;
10. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд агро-ойн аж ахуйнууд байгуулах, суулгац үржүүлгийн төв болон жимс, жимсгэний аж ахуйг хөгжүүлэх, ургамлын генетик нөөцийн ашиглалт хамгаалалт, нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх, үрийн аж ахуйг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлэх нь нэн чухал байна.

Дээрх зорилтуудыг амжилттай хэрэгжүүлснээр иргэдээ хүнсээр бүрэн хангаж, цаашлаад хүнс экспортлогч орон болох төдийгүй олон мянган ажлын байр шинээр бий болж, иргэдийн амьжиргааг дэмжих боломж бүрдэнэ.

"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг "Тэрбум мод" болон "Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэх ёстой.

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний суурь зорилгын нэг нь усны нөөцийн хомсдолоос сэргийлэх, хөрс, газрын доройтлыг сэргээх, ажлын байрыг нэмэгдүүлэх явдал юм.

Энэ нь манай улсын тогтвортой хөгжлийн суурь үндэс болно.



Хөрсөө хамгаална гэдэг бол хүнсээ хамгаална гэсэн үг, мөн тусгаар тогтнолоо хамгаална гэсэн үг

НҮБ-ын судалгаагаар манай улс жилд 2.1 тэрбум ам.доллараар үнэлэгдэх хэмжээний хөрсөө алдаж байгааг анхааруулсан байдаг.

Эрүүл, үржил шимтэй хөрсгүйгээр хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг төсөөлөх боломжгүй.

Манай улсын нийт газар нутгийн дөнгөж 0.7 хувийг эзэлдэг газар тариалангийн эдэлбэр газрынхаа хөрс, түүний үржил шимийг хайрлан хамгаалж, бүтээмжийг нэмэгдүүлж, нөөц боломжийг бүрэн ашиглахад төрийн бодлого чиглэгдэх учиртай.

Түүнчлэн хөдөө аж ахуйн кластер, ой мод, жимс жимсгэнэ, хүнс үйлдвэрлэлийн агро-паркуудыг түшиглэсэн үйлдвэрлэгч, тариаланчдын шинэ хотхонуудыг бий болгох шаардлагатай байна.

Ингэснээр нийслэл хот, төв суурин газрын хүн амын төвлөрөл саарч, хөдөө орон нутаг дахь ажлын байр олон мянгаар нэмэгдэж, эх байгаль, эрүүл орчиндоо ажиллаж, амьдрах амьдралын шинэ орчин бий болно.

Манай улсын эрхэм хүндэт ард иргэд ээ,

Монголчууд бид зөвхөн уул уурхайн салбараас гадна хөдөө аж ахуй, газар тариалангаа хөгжүүлж асар их ашиг шим, үр өгөөж хүртэх боломж байна. Үүнд дэлхийн хүн амын өсөлт, хүнсний хангамжийн асуудал ч нөлөөлж байна.



Дэлхийн долоон тэрбум хүн амын 1.6 тэрбум нь манай улсыг тойрон амьдарч байна. Бид усан далайд гаригүй ч хүн далайд гаригүй арг түмэн. Энэ бол асар том зах зээл. Энэ боломжийг бид ашиглах ёстой

"Хөтөлгөө морьтой хүн хол явдаг" гэж монголчууд ярьдаг.

Бид уул уурхайн баялгаас гадна, өсөн үржиж, урган арвиждаг хөдөө аж ахуйн баялгаараа энэ том зах зээл рүү гарцгаая.

Энэ цаг мөчөөс эхлэн бид өөрсдөө үйлдвэрлэж, эх орныхоо ариун дагшин хөрсөнд ургасан экологийн цэвэр хүнсээр хэрэгцээгээ бүрэн хангахын зэрэгцээ хүнс экспортлогч орон болох хатуу зорилго тавьж ажиллах шаардлагатай болж байна.

Энэ том зорилгыг ханган хэрэгжүүлэхэд баялаг бүтээгч тариаланчид, ногоочид, жимсчид, малчид, хүнсчид, үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд болон манай ард түмэн Та бүхэн онцгой чухал үүрэгтэй.




Харин төр, засаг нь иргэд, баялаг бүтээгчдээ бүх талаар дэмжиж, бодлого нь тодорхой, хэрэгжүүлэлт нь нээлттэй, дэмжлэг нь оновчтой, санхүүжилт нь хүртээмжтэй байж, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, төр-хувийн хэвшлийн түншлэлийг дээд зэргээр сайжруулах ёстой

Энэ хавар, зун бид хэрхэн ажиллахаас ирэх намрын ажлын үр дүн, иргэдийн хүнсний хангамж шалтгаална.

Ийм ч учраас хаврын тариалалтын эхэн үед Улсын Их Хурлын хаврын чуулганд төрийн тэргүүн оролцож, дээрх асуудалд та бүхний анхаарлыг онцгойлон хандуулж, Улсын Их Хурал, Засгийн газрыг өндөр хариуцлагатай ажиллахыг сануулж байна.

— **“Улс орныхоо тусгаар тогтнол, хөгжил дэвшил, үр хүүхдүүдийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Монголоо гэсэн зүрх сэтгэлтэй хүн бүр “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, хамтран ажиллахын зэрэгцээ эх орондоо үйлдвэрлэсэн хоол хүнс, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хугалдан авдаг эх оронч хэрэглэгч байхыг арг түмэндээ уриалж байна”** гэсэн юм.



2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилсан **"Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын төслийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн барилаа.**

Ерөнхийлөгч ирэх таван жилд гол нэрийн 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах зорилгоор "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг орон даяар өрнүүлэх санаачилга гаргасан юм.

Тогтоолын төсөлд:

- Хүнсний аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх;
- Татвар, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, санхүүжилт, даатгалын оновчтой тогтолцоо бий болгох;
- Хүүхдийн хоол, хүнсний хангамжийн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоо бий болгох, аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох;

- Пестицидийн үлдэгдлийн хяналтын хөтөлбөр батлах;

- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хөндлөнгийн хяналтын зохицуулалт бий болгох чиглэлээр хууль эрх зүйн орчинг сайжруулах, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд даалгах;

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

- Хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттай шийдвэрлэх,
- Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн бий болгох,

Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:

- Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх;
- Ургамлын генетик нөөцийн ашиглалт хамгаалалт, нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх;
- Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ болон ашигт таримлын үр үйлдвэрлэлийн үндэсний тогтолцоо бүрдүүлэх;

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:

- Нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлчээрийн даацыг тооцон малын тоо толгойг зохих түвшинд барих;
 - Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх;
- Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:
- Мал аж ахуй, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
 - Хүнсний сүлжээний бүх шатанд хяналт, баталгаажуулалтыг тодорхой болгож



итгэмжлэгдсэн лабораторын хүчин чадлыг нэмэгдүүлэх;

- Дотоодын зах зээлд борлуулсан чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгож буй урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох;
- Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах зэрэг цогц арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар тусгалаа.





Ерөнхийлөгчийн Тамгын
газрын дарга **Я.Содбаатар**

“ УИХ-ын чуулганаар хүнсний хангамж, аюулгүй байдалтай холбоотой түүхэн шийдвэр гаргасан. Өөрөөр хэлбэл ирэх таван жилийн хугацаанд Монгол Улс гол нэрийн 19 бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах боломж бүрдлээ.

Хууль, эрх зүйн таатай орчин, хөрөнгө, санхүү, татварын дэмжлэг, техник, технологийн шинэчлэлт, хүний нөөц зэрэгт анхаарна. Бид баялаг бүтээгчид, эрдэмтэн судлаачид, газар тариалан эрхлэгчдийнхээ зөвлөгөө, санал хүсэлтийг сонсож, ажилдаа тусгана. Хүн бүрийн дэмжлэг, оролцоо чухал байна.

**"Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар
авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын
төслийг анхны хэлэлцүүлэгт шилжүүллээ**

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тогтоолын төслийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулсан.

Манай улсын гол нэрийн 16 нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс малын мах, улаан буудай, гурил, төмсийг дотоодоосоо 100 хувь хангаж байна. Харин сүүн бүтээгдэхүүн 27.1, гурилан бүтээгдэхүүн 38.2, хүнсний ногоо 38.5, өндөг 48.6, цөцгийн тос 67.4, тахианы мах 98, ургамлын тос 98.5 хувь нь импортын хамааралтай байгаа аж. Байгаль, цаг уурын онцлогоос шалтгаалан тариалах боломж хязгаарлагдмал буурцагт ургамал, бүх төрлийн будаа, элсэн чихэр, загас, загасан бүтээгдэхүүн 100 хувь, хүнсний сав баглаа боодлын үндсэн түүхий эдийн 95 хувийг импортоор авч байна. Манай улс 2021 онд 962 сая ам. доллар буюу 2.7



их наяд төгрөгийн хүнс импортолсон бөгөөд жилд дунджаар 2.5 их наяд төгрөгийн импорт хийж байна.

Манай улс 2030 он хүртэлх хугацаанд малын мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүнийг дотооддоо бүрэн хангаж жилд дунджаар





2022.05.24. Төрийн ордон.
Байнгийн хорооны
хуралдаан

95.4 мянган тонн малын мах, 54.6 мянган тонн махан бүтээгдэхүүн, 288 мянган тонн сүү, сүүн бүтээгдэхүүн, 111 мянган тонн гурил, 21 мянган тонн гурилан бүтээгдэхүүн экспортлох боломжтой. Хүн амын хэрэгцээт жимс жимсгэний 23, ургамлын тосны 69, хүлэмжийн ногооны 41, элсэн чихрийн 41, төрөл бүрийн будааны 44 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангаж, ил талбайн ногоо, тахианы мах, өндөг, гахайн мах, өөхийг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах боломжтой аж. Түүнчлэн дээрх гол нэрийн 19 нэр төрлийн хүнсний түүхий

эдийг бэлтгэхэд одоо байгаа усалгаагүй 557 мянган га талбай дээр шинээр 479 мянган га талбай, усалгаатай 30 мянган га талбай дээр шинээр 33 мянган га талбайг эргэлтэд оруулж, жилд 1931 мянган тонн тэжээл шаардлагатай гэсэн тооцоо гарч байна. Иймд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоодоосоо хангах, зөвхөн хүнс хөдөө аж ахуйн салбар бус улсын хэмжээнд нийт салбарын хүрээнд хамтран ажиллах, хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлын хангах чиглэлээр нэгдсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.



ХХААХҮ-ийн сайд

3.Мэндсайхан:

“Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангахад зөвхөн хүнс, хөдөө аж ахуйн салбар бус улсын хэмжээнд, нийт салбарын хүрээнд хамтран ажиллах, нэгдсэн бодлого хэрэгжүүлэх нь Хүнсний хувьсгалын гол зорилго.

Цар тахал, гадаад нөхцөл байдал, тээвэр ложистик зэргээс болж дэлхий нийтэд хүнсний хангамжийн тогтвортой байдалд эрсдэл бий болж байна.

Манай улс 2030 он хүртэлх хугацаанд малын мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангах боломжтой. Цаашид жилд дунджаар 95.4 мянган тн малын мах, 54.6 мянган тн махан бүтээгдэхүүн, 288 мянган тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 111 мянган тн гурил, 21 мянган тн гурилан бүтээгдэхүүн экспортлох боломжтой гэсэн тооцоо бий.





Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх ирэх таван жилд гол нэрийн 19 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангахыг уриалж, Хүнсний хувьсгал хийх санаачилгын хүрээнд

ХҮНС ҮЙЛДВЭРЛЭГЧИДТЭЙ УУЛЗАЖ, ТАРИАЛАНГИЙН БҮС НУТАГТ АЖИЛЛАСАН.

Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч мах, ногооны хөргүүртэй агуулах, хүлэмжийн аж ахуй болон шувууны аж ахуй эрхлэгчидтэй уулзаж, тулгарч байгаа хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар санал солилцлоо. Мөн Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг дахь хаврын тариалалтын явцтай танилцаж, тариаланч, ногоочдын төлөөлөлтэй уулзав.



Татварын асуудлыг хууль, эрх зүйн хүрээнд зохицуулбал өндөгний хэрэгцээг дотоодоос бүрэн хангах боломжтой”

“Түмэн шувуут” ХК-ийн өндөглөгч тахианы аж ахуй нь 430 мянган шувуутай бөгөөд жилд 80 сая ширхэг өндөг үйлдвэрлэж байна. Энэ нь манай улсын өндөгний хэрэглээний 23 хувь, дотоодын зах зээлийн 45 хувийг хангадаг гэсэн үг юм.

2019 оноос үйлдвэрлэлээ өргөтгөн СХД-ийн 21 дүгээр хороо, Их булагт “Түмэн шувуут-2” төсөл хэрэгжүүлж эхэлсэн. Одоогоор 40 мянган дэгдээхийн нэг, өндөглөгч тахианы дөрвөн байр ашиглалтад оруулаад байна.

Ингэснээр “Түмэн шувуут” ХК жилд 150 сая ширхэг өндөг үйлдвэрлэх бөгөөд дотоодын өндөгний хэрэглээг ойрын гурван жилд 100 хувь хангах боломжтой болох юм.

Манай улс нийт өндөгний хэрэгцээнийхээ талаас дээш хувийг импортоор хангадаг. Чөлөөт бүсэд

Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх
“Түмэн шувуут” ХК-ийн
өндөглөгч тахианы аж ахуйд
ажиллалаа. 2022.05.17





долоо хоногт 600 мянган ширхэг өндөг гадаадаас татваргүй орж ирдэг нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэл болдог тухай шувууны аж ахуй эрхлэгчид ярилаа. Мөн урт хугацаатай, бага хүүтэй зээл олгох чиглэлээр төр, засгийн зүгээс бодлогын арга хэмжээ авахыг хүсэж байлаа.



Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх:



Хүнсээ дотоодоос бүрэн хангахын тулд төр, засгаас боломжтой бүх дэмжлэг, туслалцаа үзүүлнэ”



СХД-ийн 32 дугаар хороо “Монголиан грийн фармер” ХХК мах, ногооны хөргүүртэй агуулах. 2022.05.17



Ерөнхийлөгч мөн СХД-ийн 32 дугаар хороонд байрлах “Монголиан грийн фармер” ХХК-д ажиллаж, мах, ногооны хөргүүртэй агуулахтай танилцлаа.

“Монголиан грийн фармер” ХХК 2015 онд байгуулагдсан. Хөргүүртэй агуулахын хадгалалт, борлуулалт, түрээсийн үйлчилгээ, мах, махан бүтээгдэхүүн, жимс, хүнсний ногооны хадгалалт, борлуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Голландын бүрэн автомат технологи, тоног төхөөрөмж бүхий агуулах нь 1,500 тн мах, хөлдөөсөн хүнс, 1,500 тн жимс, хүнсний ногоо хадгалах хүчин чадалтай. Цаашид Улаанбаатар хотод 45 мянган тонны багтаамжтай агуулах барихаар төлөвлөсөн тухай компанийн гүйцэтгэх захирал Ш.Гүррагчаа танилцууллаа.





Зориулалтын хөргүүртэй агуулахгүй бол иргэдээ эрүүл хүнсээр хангах тухай ярих боломжгүй. Иймээс агуулахтай болгох талаар төр, засгийн зүгээс боломжит бүх хэлбэрээр дэмжинэ”



Манай улс хүнсний ногооны 40 орчим хувь буюу 70 орчим мянган тонныг импортоор авдаг. 50 мянган тонны хүчин чадал бүхий хөргүүртэй агуулах барьсан тохиолдолд ногоочид ногоогоо талбай дээрээсээ боломжийн үнээр борлуулах, хадгалалтад санаа зовохгүй байх, намрын цагт олох ашиг, орлого нь тодорхой болох зэрэг давуу талтай. Өөрөөр хэлбэл импорт буурч, иргэд эрүүл хүнс хэрэглэхээс гадна үнэ тогтворжих, ченжийн гэгдэх тогтолцоог халах, ложистикийн зөв систем бий болох, өрхийн аж ахуй хөгжих ач холбогдолтой.

300 тэрбум төгрөгөөр 50 га талбайд хүлэмж барихад нийслэлчүүдийн хэрэгцээг бүрэн хангана

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Төгс ургац” ХХК-ийн хүлэмжийн аж ахуйтай танилцлаа. Тус компани Голланд загварын 18,000 м² хүлэмжийг 2016 онд Улаанбаатар хотын СХД-ийн 21 дүгээр хороонд байгуулсан байна.

Тус хүлэмж нь халаалт, усалгаа, бордоо, агаарын чийгшлийн тохируулга зэрэг орчин үеийн технологийн шаардлагыг бүрэн хангасан, жилийн дөрвөн улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг.



Өдөр бүр 2-4 тн улаан лооль, өргөст хэмхийг Барс зах болон Е-март, Номин, Сансар зэрэг томоохон сүлжээ дэлгүүрээр борлуулдаг. Өндөр хүүтэй зээл, хүлэмжийн чиглэлийн мэргэжилтэн дутмаг зэрэг нь үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд хүндрэл учруулдаг тухай компанийн захирал Л.Эрдэнэчимэг танилцууллаа.

50 га талбайд шаардлага хангасан хүлэмж барихад 300 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд урт хугацаатай, хүү багатай зээл авбал нийслэлчүүдийн хэрэгцээг бүрэн хангаж, орон нутагт нийлүүлэх бүрэн боломжтой тухай хүлэмжийн аж ахуй эрхлэгчид ярилаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нийслэл хоттой хамтарч 15 га талбайд хүлэмжийн аж ахуй байгуулахаар төлөвлөсөн. Цаашид агуулах, хүлэмжийн аж ахуйг дэмжих чиглэлээр гурван хувийн хүүтэй, хоёр жилийн хугацаатай зээлд аль болох түлхүү хамруулах бодлого баримталж байгааг сайд З.Мэндсайхан хэллээ.



Тариаланчид мал аж ахуй, газар тариалангийн бүс нутгийг заагласан хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг хүсэж байна

Төв аймгийн Жаргалант сумын тариалангийн талбай



Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх:



Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх суурь асуудлын нэг нь хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, улмаар хүнс экспортлогч орон болох явдал. Ялангуяа ирэх таван жилд Хүнсний хувьсгал хийх зорилтыг биелүүлэхэд газар тариалан болон хүнсний ногоо эрхлэгчид чухал хувь нэмэр оруулах учир хуулийн хүрээнд бүх талын туслалцаа, дэмжлэг үзүүлнэ. Мөн Улсын Их Хурал, Засгийн газар хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр авах арга хэмжээтэй холбоотой хуулийн төслийг ойрын хугацаанд хэлэлцэн шийдвэрлэнэ гэдэгт итгэлтэй байна.”



Сэлэнгэ аймаг, Мандал сум "Макс Агро" ХХК-ийн эрчимжсэн мал аж ахуйн ферм

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Төв аймгийн Жаргалант суманд ажиллаж, "Хөх Баянбулаг" ХХК болон ногоочдын хаврын тариалалтын явцтай танилцлаа.

"Хөх Баянбулаг" ХХК 6,160 га эргэлтийн талбайтай. Жилд дунджаар 2,000-2,700 га-д тариалалт хийж 3,000-4,000 тн ургац хураадаг. Энэ жил 2,000 га-д буудай, 1,200 га-д тосны ургамал тариалж, 2,800 га-д уринш боловсруулахаар ажиллаж байна.

Мал аж ахуй, газар тариалангийн бүс нутгийг заагласан хууль тогтоомж байгаа ч хэрэгжилт нь тааруу байгаа талаар тариалан эрхлэгчид ярьж байлаа.

Хэрэгцээт төмсний талаас илүүг зах зээлд нийлүүлдэг Төв аймгийн Жаргалант сумын ногоочид импортын хүнсний ногоонд өндөр татвар ногдуулах, Улаанбаатар хотод борлуулалтын цэг байгуулах, урт хугацаатай, бага хүүтэй зээл олгоход дэмжлэг үзүүлэхийг хүслээ.

"Байр, хоолтой, өдрийн 50 мянган төгрөг өгнө" гэдэг ч ажиллах хүн олдохгүй байгаа нь халамж хавтгайрсантай холбоотой гэж цөөнгүй ногоочин хэлж байлаа.

Мөн урамшууллаас гадна Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй үр, аймгаас Итгэлийн зээл олгосон нь ажлаа хэвийн явуулахад нэмэр болсонд ногоочид талархаж байгаагаа илэрхийллээ.

Мах, гурил, төмсөөр хэрэгцээгээ бүрэн хангаж байгаагаа улам бататгах, цаашид гурилан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг зэргийг бусдаас гуйхгүй хэмжээнд байхын төлөө дор бүрнээ хичээн ажиллах ёстойг төрийн тэргүүн газар тариалан болон төмс, хүнсний ногоо эрхлэгчдэд захилаа.



Хүнс үйлдвэрлэгчид урт хугацаатай, хүү багатай зээлийн дэмжлэг хүсэж байна

Энэ жил Орхон суманд 700 орчим иргэн, 30 орчим аж ахуйн нэгж, байгууллага 1,300 га талбайд 12 төрлийн төмс, хүнсний ногоо тариалсан байна.

Ногоочид Шарын голын усалтын системийг орон нутгийн өмчид авч иж бүрэн сэргээн засварлах, "Хөдөө аж ахуйн, техник үйлчилгээний дундын төв" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг өргөтгөх, лууван хураах дунд оврын хоёр комбайныг дээрх төвд олгох, дахин боловсруулах үйлдвэрийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхийг хүсэж байлаа. Ногоочдын хүсэлтийг судалж, шийдвэрлэхийг Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх ХХААХҮ-ийн сайд болон холбогдох байгууллагын удирдлагуудад чиглэл болголоо.

Ерөнхийлөгч мөн ногоочдын тарьжургуулсан өргөст хэмх, хүнсний ногоог олон жилийн турш худалдан авдаг, тэднийг төрөл бүрээр дэмжиж хамтран ажилладаг "ГБТ трейдинг", "Баясах фүүд" компанийн төлөөлөлтэй уулзлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх:

“Цаашид төр засаг, хувийн хэвшил хамтарч ажиллаж байж, ирэх таван жилд хүнснийхээ хэрэгцээг дотоодоос хангах зорилтдоо хүрнэ. Мөн үндэсний үйлдвэрлэлээ дэмжихийн тулд ард иргэд, байгууллага, аж ахуйн нэгж бүр эх оронч худалдан авалт хийцгээе”

Аж ахуйн нэгжүүд НӨАТ-аас чөлөөлөх, урт хугацаатай, хүү багатай зээл олгоход туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг хүслээ. "ГБТ трейдинг" компани гэхэд л ажлаа хэвийн явуулахын тулд жилийн 18 хувийн хүүтэй зээлийг Банк бус санхүүгийн байгууллагаас авдаг байна.

Цаашид төр, засаг, хувийн хэвшил хамтарч ажиллаж байж, ирэх таван жилд хүнснийхээ хэрэгцээг дотоодоос хангах зорилтдоо хүрнэ гэдгийг Ерөнхийлөгч хэллээ.

Аж ахуйн нэгжүүдээ татварын бодлогоор дэмжих, урамшуулал үзүүлэх, хүү багатай, урт хугацаатай зээл олгох, техник, технологийг нь шинэчлэх, хөргүүртэй агуулахтай болох, мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх зэргийг цогцоор нь авч үзэх шаардлагатай гэж үзэж байна.

Үндэсний үйлдвэрлэлээ дэмжихийн тулд ард иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдийг эх оронч худалдан авалт хийж байхыг Ерөнхийлөгч уриаллаа.



Зураг: Дархан-Уул аймгийн Орхон сум. 2022.05.18





**Шаардлага
хангасан 30 ферм
байгуулснаар
дотоодын сүүний
хэрэгцээг бүрэн
хангах боломжтой**



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх газар тариалангийн бүс нутагт ажиллах үеэрээ Сэлэнгэ аймгийн Мандал суманд үйл ажиллагаа явуулдаг "Макс Агро" ХХК-ийн ажилтай танилцлаа.

"Макс" групп, "Сүү" ХК хамтран 2014 онд Бүгд Найрамдах Словак Улсаас Глоштейн үүлдрийн 300 үнээ оруулж ирэн, "Макс Агро" эрчимжсэн мал аж ахуйн цогцолбор ферм байгуулсан байна.

Энэ үүлдрийн үнээ саалийн 305 хоногтоо 7500-14000 литр сүү өгдөг, амьдын жин нь дунджаар 700 кг юм.

"Макс Агро" ХХК жилд 20 орчим тэрбум төгрөгийн сүүг 2,500 бэлтгэн нийлүүлэгч, малчнаас авч "Сүү" ХК-д нийлүүлдэг. Цаашид үйл ажиллагаагаа өргөтгөн одоо байгаа 500 үнээгээ 1,000 болгох зорилт тавиад байна.

Мөн өнгөрсөн онд байгуулсан долоон хоршоог энэ жил 10 болгон, олон малчинг хамтарч ажиллах, мал, малын ашиг шимээ эргэлтэд оруулахад нь туслахаар төлөвлөжээ.

Энэ салбарынхныг усалгааны систем, фермийн тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй үнээр авах, эргэлтийн хөрөнгөтэй болох зэргээр кластераар нь дэмжих шаардлагатай байна.



Зураг: Сэлэнгэ аймаг, Мандал сум "Макс Агро" эрчимжсэн мал аж ахуйн цогцолбор ферм. 2022.05.18

"Сүү" ХК-ийн гүйцэтгэх захирал **М.Болод**:

"Манай улс сүүнийхээ 50 хувийг л дотоогоос хангадаг. Орчин үеийн шаардлага хангасан, дэвшилтэт техник, технологи бүхий 30 ферм буюу 9,000 Глоштейн үүлдрийн үнээтэй байвал дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, 2026 оноос экспортод гаргах боломжтой"

Сүүний зах зээлийг тэлэх, малчдыг дэмжих үүднээс үйлдвэрийн аргаар боловсруулсан литр сүү тутамд 500 төгрөгний урамшуулал олгодог. Үүнийг бүтэн жилээр нь өгвөл эрчимжсэн мал аж ахуй хөгжих, малчид хорших томоохон хөшүүрэг болох юм байна.

Монгол хүн жилд 160 кг сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэх ёстой гэж ДЭМБ үздэг ч энэ хэмжээ 80 орчим кг байна. Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангахад 60 сая ам.доллар шаардлагатай гэсэн тооцоог Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам гаргажээ.





Үндэсний үйлдвэрүүд нэгдэн, ургамлын тос үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангахыг зорьж байна

Сэлэнгэ аймаг, Баянгол сум “Эзэгтэй” ургамлын тосны үйлдвэр. 2022.05.18

“Майнд Теч” ХХК хар рапсын үрийг Сэлэнгэ аймгийн Баянгол суманд байрлах “Сэлэнгэ” үйлдвэрт боловсруулж “Эзэгтэй” нэртэйгээр зах зээлд нийлүүлж байна.

Үйлдвэр хоногт 100 тн тослог ургамлын үр боловсруулах хүчин чадалтайгаар ажиллаж эхэлсэн байна. Цаашид 300 тн болгож нэмэх боломжтой, бүрэн автомат үйлдвэр юм.

Ард санхүүгийн нэгдэл “Гүүд” платформоор дамжуулан рапс тариалах, хураах, боловсруулах, ургамлын тос үйлдвэрлэх, хэрэглэгчдэд хүргэх бүх шат дамжлагыг шаардлагатай санхүүжилтээр хангаж байна.

Үүний дүнд “Эзэгтэй” ургамлын тосыг БНСУ-д гаргаж эхэлсэн бөгөөд эхний үед 800 тн тос нийлүүлэхээр гэрээ хийжээ.

Үндэсний аж ахуйн нэгжүүд нэгдэн эх орондоо ургамлын тос үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлэхээс гадна экспортод гаргаж байгаа нь чухал гэдгийг Монгол Улсын Ерөнхийлөгч хэлж, энэ чиглэлээр төр, засаг боломжит бүх талын дэмжлэг үзүүлэх ёстойг онцлов.

Рапсыг экспортод гаргах тусам ургамлын тосоо үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлэх боломж буурах эрсдэлтэйг үйлдвэрлэгчид ярьж байлаа.

Иймээс ургамлын гаралтай хүнсний тостой ижил төрлийн импортын бүтээгдэхүүний гаалийн татварыг нэмэх, тариа, гурил үйлдвэрлэгчдэд үзүүлж байгаатай адил рапс болон түүгээр хийсэн хүнсний тос, тэжээлийг НӨАТ-аас чөлөөлөх, стандартын бус рапсын үрээр тариалалт хийж байгааг зогсоох нь зүйтэй гэж үзэж байна.

“Майнд Теч” ХХК-ийн гүйцэтгэх захирал
Б.Мөнхбаяр:




Бид ургамлын тос боловсруулж зах зээлд нийлүүлэхээс гадна биодизель, малын хүчит тэжээл үйлдвэрлэдэг. Тухайлбал ашигласан тос худалдан авч биодизель үйлдвэрлэн өөрийн хэрэгцээгээ 100 хувь хангадаг. Цаашид хоногт 20-50 тн болгохоор төлөвлөж байна”



Ажлын хэсэг байгуулах тухай Улсын Их Хурлын даргын захирамж гарлаа

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл ажил хангах, шаардлагатай тохиолдолд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий "Ажлын хэсэг байгуулах тухай" захирамжийг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр гаргалаа.





Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Хэнтий аймагт ажиллалаа

Зураг: Хэнтий аймаг, Мөрөн сум. 2022.06.03



Зураг: Хэнтий аймаг, Мөрөнгийн тариалангийн талбай. 2022.06.03



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Хэнтий аймагт ажиллалаа. Энэ үеэрээ Хэнтий аймгийн Мөрөн сумын ногооны талбай, усалгааны системийн суурь баазаар орж, тариалан эрхлэгчидтэй уулзлаа.

Ирэх таван жилд гол нэрийн 19 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлэх хүрээнд "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганаар хэлэлцүүлж байгааг Ерөнхийлөгч хэллээ. Мөн хүнсээ дотоодоос бүрэн хангадаг болохын тулд төр, засгаас боломжтой бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлнэ гэдгийг онцлов.



Хэнтий аймгийн ногоочин:

Би төрийн албан хаагч байсан. Ажлынхаа хажуугаар ногоогоо тариад идчихдэг, хүмүүст илүүчилчихдэг байлаа. Ерөнхийлөгчийн санаачилгыг 100 хувь дэмжиж байгаа”

Мөрөн сумынхан Мөрөн голоо түшиглэн 1944 оноос Эрдэнэ уулын зүүн талд төмс, хүнсний ногоо бага хэмжээнд тариалж эхэлснээс хойш 78 дахь жилдээ тариалалтаа эхэлжээ.

Сумын 102 өрхийн 155 ногоочин, гурван аж ахуйн нэгж малын тэжээл, рапс, улаан буудай, төмс, хүнсний ногоо, хоёр иргэн чацаргана тариалж байна.

2018 оноос хүлэмжийн аж ахуй эрхэлж байгаа бөгөөд 594 м.кв талбай бүхий 16 хүлэмжтэй. Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр 128 м.кв гурван улирлын хүлэмжийг 2019 онд барьж энэ жилээс ашиглаж эхэлжээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас сумын тариаланчдад зориулж 90 морины хүчтэй трактор, анжис, борной, чиргүүлийг хүлээлгэн өглөө. Цаашид Мөрөн сумын хүнсний ногооны талбайн усалгааны системийн суурь баазыг бүрэн шинэчлэхээр болсныг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан хэлэв.

Хэнтий аймгийн Мөрөн сум 2021 онд 678 тн төмс, 548 тн хүнсний ногоо хураан авсан байна. 2010, 2014 онд Улсын аварга тариаланч сум, 2017, 2020 онд Тариаланч сумаар шалгарч байжээ.

“Хэдийгээр 100 тонны хүчин чадалтай зоорьтой ч цаашид өргөтгөх, аймгийн төвд ногоогоо худалдан борлуулах байнгын цэгтэй болох шаардлага байгааг ногоочид хэлж байлаа. Мөн 60 га тариалангийн талбайн усалгааны системийн суурь баазыг шинэчлэн засварласнаар эргэлтийн талбайг 200 га болгож тэлэх боломжтой гэдгийг танилцуулж, дэмжлэг хэрэгтэй байгаа тухай ярилаа.”



Зураг: Хэнтий аймаг, Хэрлэн сумын нутагт хэрэгжих “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан” төслийн явцтай танилцлаа. 2022.06.04

Хэнтий аймаг 700 га талбайг усалгааны системтэй болгох төсөл хэрэгжүүлнэ

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Хэнтий аймагт ажиллах үеэрээ “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан” төслийн явцтай танилцлаа.

Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сан болон Засгийн газар хамтран хүнсний ногооны 700 га талбайг усжуулахаар 2019 оноос судалгаа хийсэн бөгөөд хоёр жилийн дараа ашиглалтад оруулах юм.

Төсөл хэрэгжсэнээр сүүлийн үеийн дэвшилтэт технологи нэвтрэх, хүнсний ногооны тариалах талбайн болон хураан авах ургацын хэмжээ одоогийнхоос 5–6 дахин нэмэгдэх, тариалах таримлын төрөл зүйл нэмэгдэх, шинэ таримал сортуудыг нутагшуулах, Чингис хот болон ойрын сумд, Дорнод, Сүхбаатар аймагт бүтээгдэхүүнээ нийлүүлэх, хүнсний нарийн ногооны үр үйлдвэрлэх боломж бүрдэнэ.

Төслийн дараах тариалалт хийхийн тулд хөрс боловсруулахаас эхлээд тариалах, ургалтын үеийн арчилгаа, хураалт хийх 100 мориноос дээш хүчин чадалтай трактор, иж бүрэн техник, тоног төхөөрөмж шаардлагатай байна.

Хэрлэн сумын хувьд 60 га талбайд төмс, 36 га талбайд 13 аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо, нөхөрлөл, 15 иргэн хүнсний ногоо тариалж байна.

Тариаланчид Чингис хотын хүн амын төмсний 57, хүнсний ногооны 28 хувийг хангадаг бөгөөд одоогийн тариалж байгаа талбайг төмсөнд 50 га, хүнсний ногоонд 90 гаруй га талбайгаар нэмбэл дотоодын хэрэгцээгээ 100 хувь хангах боломжтой юм.

5,854 м.кв талбай бүхий 76 ширхэг зуны хүлэмж, 680 м.кв талбай бүхий зургаан ширхэг гурван улирлын хүлэмжинд тариалалт хийж байна.

1,195 тн ургац хадгалах зоорьтой боловч 250 тн-ын зоорийг нь ашиглах боломжгүй учир нийт ургацын 65 хувийг хадгалдаг. Ургацаа бүрэн хадгалахад 1,000 тн, орон нутгийн хэрэгцээг хангах хэмжээний тариалалт хийхэд 3,000 тн-ын зоорь шаардлагатай байгаа тухай тариаланчид ярилаа.

Цаашид төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг даатгалтай болгох, өрхийн хэрэгцээнд үнэ төлбөргүй олгодог 0,1 га талбайн хэмжээг нэмэгдүүлэх, тариалангийн бүс нутагт зөвхөн эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх, төрөөс тогтвортой үнийн бодлого баримтлах зэрэгт анхаарах хүсэлт гаргалаа.

Энэ үеэр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Дундын техник үйлчилгээний төвтэй болгох зорилтын эхлэл болгож Хэрлэн сумын ногоочдод 32 морины хүчтэй хоёр трактор хүлээлгэн өглөө.



Хөрсөө хамгаалахын зэрэгцээ арвин ургац авах боломжтой тариалалтын аргыг амжилттай нэвтрүүлж байна



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх мөн Хэнтий аймгийн Хэрлэн суманд найман жилийн турш ашиглаж, үр өгөөжөө өгч буй тариалалтын аргатай танилцлаа.

"Хэнтий тариалан" компани 2014 оноос хойш хөрсний үржил шим багатай, салхи ихтэй талбайд зохицсон тариалалтын аргыг амжилттай туршиж, өнгөрсөн жил нэг га-гаас 22 центнер ургац хураан авсан.

Тус компани га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, талбайн ашиглалтын сайжруулж сэлгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, га талбайн зардлыг багасгах, ургамал хамгааллын бодис-гербицидын хэрэглээг бууруулах, эко хүнс үйлдвэрлэх технологи бий болгохыг зорьж байна.



УИХ-ын гишүүн
Б.Бат-Эрдэнэ:



Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүхийн
санаачилгын хүрээнд сум, орон
нутагтаа хийж байгаа, баялаг
бүтээж байгаа хүн болгоныг бүх
талаар дэмжих ёстой”



Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх:



Ойрын 5 жилийн хугацаанд
хүнсний хэрэгцээгээ
дотоогоосоо бүрэн хангадаг
болох зорилтог энэ арга
маш чухал үүрэгтэй. Бид
органик хүнс экспортлогч
орон болох бүрэн
боломжтой. Энэ зорилгын
төлөө хамтран ажиллая”

Технологи болж хараахан хөгжөөгүй байгаа ч энэ аргаар тариалалт хийснээр хөрсний чанар сайжирч нэг га-гаас дунджаар 25 центнер үр тариа хураан авах боломжтой. Хөрсийг аль болох хөндөхгүй, хөрсний байгалийн дүр төрхийг нь хадгалах замаар жил ирэх тусам хөрсөө сайжруулаад явдаг. Уринш боловсруулж, хөрсөө өнжүүлэхгүйгээр жил бүр тариалалт хийдэг, дөрөвдүгээр сард тариалалтаа эхлүүлээд наймдугаар сард ургацаа хураан авдаг гээд олон талын ач холбогдолтой юм. Энэ технологийг Хэнтий аймгийн сумд төдийгүй Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Дархан, Сэлэнгэ зэрэг найман аймагт нэвтрүүлж, хэд хэдэн компани туршилт хэлбэрээр ашиглаж эхэлжээ.



Хэнтий аймгийн ХХААХТ-ийн мэргэжилтэн Н.ГАНЧИМЭГ:



Манай сумын өрх бүр өөрсдийн хүнсний ногоогоо тариалдаг болохоор зорьж байна. Мөн илүү гарсан ногоогоо бусад сум, орон нутаг руу түгээнэ”

“ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ-ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг орон даяар өрнүүлж буйтай холбоотойгоор хүнсний боловсруулах үйлдвэрүүд үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд сурталчлав.

Үзэсгэлэн худалдаанд 57 аж ахуйн нэгж, мэргэжлийн гурван холбоо оролцож эх орондоо үйлдвэрлэсэн, эрүүл эко хүнсний бүтээгдэхүүнээ танилцуулж, хямдралтай, урамшуулалтай үнээр худалдлаа.



Хүнсний хувьсгал эхлүүлснээрээ үйлдвэрлэгчид болон баялаг бүтээгчдийн хүсч хүлээж байсан олон асуудал шийдэгдэнэ.

Монгол Улсад хүнс боловсруулах 1,880 гаруй үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна. Цар тахлын хүнд цаг үед энэ салбарынхан гар хумхилгүй ажиллаж, хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл 2021 онд 2.8 их наяд төгрөгт хүрсэн. Боловсруулах салбарт хүнсний үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин сүүлийн 10 жилийн хугацаанд дөрөв дахин, хүнсний дотоодын үйлдвэрлэл биет хэмжээгээр 1.5 дахин нэмэгдсэн.





Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн хэт өсөлтийг саармагжуулах зорилгоор гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай, гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг Улсын Их Хурал баталж, цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тосыг гаалийн албан татвараас чөлөөлөв.

Мөн 12.7 мянган тонн нөөцийн мах бүрдүүлж, нийслэлчүүдийн хэрэгцээнд нийлүүлж, 19.2 сая литр сүүнд 9.5 тэрбум төгрөгийн урамшуулал олгож, нийт 550 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох шийдвэр гаргаад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн үйлдвэр, үйлчилгээ хариуцсан бодлогын зөвлөх **Ч.Даваабаяр:**



Хүнсний хувьсгалыг эхлүүлснээр баялаг бүтээгчдийн хүсэн хүлээсэн олон асуудал шийдэгдэнэ. Хүнс бол хүний хэрэгцээ, нийгмийн хэрэгцээ, хөгжлийн гол тулгуур”



Монгол Улс 45 хувиас дээш импортын хүнс хэрэглэж байна. Дотоодын үйлдвэрүүдийг яаралтай хөгжүүлж, хяналт шалгалтаа багасгаж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Баялаг бүтээгчдийн хүсдэг зүйл бол төрийн дарамтыг байхгүй болгох, бага хүүтэй, урт хугацаатай зээл авах, төрийн худалдан авалтыг дэмжих юм. Ерөнхийлөгч улс орон даяар Хүнсний хувьсгал эхлүүлснээр үйлдвэрлэгчид болон баялаг бүтээгчдийн хүсэж хүлээж байсан олон асуудал шийдэгдэнэ гэдэгт итгэлтэй байгаагаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн үйлдвэр, үйлчилгээ хариуцсан бодлогын зөвлөх Ч.Даваабаяр хэллээ.





Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх:



Эрүүл, аюулгүй хүнсний хувьсгалыг хийх эгэл баатрууд бол хүнсчид та бүхэн шүү” гэдгийг онцлоог “Монгол Улс далайд гарцгүй ч хүн нь далайд гарцтай орон. Тиймээс үйлдвэрлэж, ургуулж, импортлож, экспортлож, борлуулж буй хүнс эрүүл байх ёстой. Төр засгийн бодлого ч дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах, дэмжихэд чиглэж байх ёстой”

“Хүнсний хангамж, аюулгүй байдал – Хүнс үйлдвэрлэл” үндэсний зөвлөгөөн

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг улс орон даяар өрнүүлэх эхлэлийг тавих, хүнсний сүлжээнд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх гарц, гаргалгааг эрэлхийлэх зорилготой “Хүнсний хангамж, аюулгүй байдал-Хүнс үйлдвэрлэл” сэдэвт үндэсний зөвлөгөөн 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Төрийн ордонд боллоо.

Зөвлөгөөнийг нээж Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, ХХААХҮ-ийн сайд З.Мэндсайхан, УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Х.Болорчулуун нар үг хэлсэн бөгөөд хүнсний салбарын аж ахуйн нэгжийн төлөөлөгч, эрдэмтэн судлаачид, олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцож, илтгэл хэлэлцүүлсэн юм.

Энэхүү санаачилгын нэг зорилт нь “Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлж, бүс нутагтаа органик хүнс экспортлогч улс болох” юм. Энэ хүрээнд төрийн зүгээс хүнсний





ХХААХҮ-ийн сайд
З.Мэндсайхан:



Монгол Улсад хүнс боловсруулах 1,900 гаруй үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна. Цар тахлын хүнд цаг үед манай боловсруулах үйлдвэрийнхэн гар хумхилгүй ажиллаж, хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийг өргөжүүлсэн таатай мэдээтэй байна. Тухайлбал, энэ төрлийн үйлдвэрлэлийн орлого 2021 онд 2.8 их наяд төгрөгт хүрч, боловсруулах салбарт хүнсний үйлдвэрийн эзлэх хувийн жин сүүлийн 10 жилийн хугацаанд гөрөв дахин, хүнсний дотоодын үйлдвэрлэл биет хэмжээгээр 1.5 дахин нэмэгдсэн”

талаар баримтлах бодлогоо шинэчлэн тодорхойлж, хүнсний хангамж, аюулгүй байдлын асуудлаар шийдэмгий алхмыг эхлүүлж байгааг хэлж байв. Мөн энэ зорилтыг ханган хэрэгжүүлэхэд баялаг бүтээгч тариаланчид, ногоочид, жимсчид, малчид, хүнсчид, үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд болон нийт ард иргэдийн хичээл зүтгэл, хүчин чармайлт онцгой чухал ач холбогдолтой. Түүнчлэн, салбарын эрдэмтэн судлаачид, баялаг бүтээгч үйлдвэрлэгчид, хүнсний технологичид, инженерүүд, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн манлайлал, оролцоо хүнсний хувьсгалыг амжилттай хийж, хэрэгжүүлэхэд онцгой үүрэгтэй болохыг цохон тэмдэглэж байлаа.

Дэлхий нийтэд сүүлийн жилүүдэд тохиолдсон цар тахал, гадаад нөхцөл байдлаас шалтгаалан улс орнууд хүнсний хангамж, аюулгүй байдалдаа онцгой анхаарч байгаатай холбоотой Монгол Улс ч эх орны хөрсөнд тарьж ургуулсан эрүүл хүнс үйлдвэрлэлдээ гойд анхаарч эхэлж байна. Хүнсний салбараа бодлогоор дэмжсэнээр хүн ардынхаа эрүүл мэндийг хамгаалаад зогсохгүй эдийн засаг, үйлдвэрлэлээ бэхжүүлэх юм.

Монгол Улс өнгөрсөн онд 291.5 сая ам.долларын 16 гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн импортложээ. Үүнийг 2020 онтой харьцуулахад 25.8%-иар өссөн байна. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импортын хамаарлын 2021 оны түвшинг 2010 онтой харьцуулахад гурил 30%, гурилан бүтээгдэхүүн 9%, төмс 5%, цөцгийн тос 0.6%-иар тус тус буурч, сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс, жимсгэнэ, өндөг, ургамлын тос, элсэн чихэр, чихрийн зүйл, загасны мах, хүнсний ногоо 38.4-100% хамааралтай хэвээр байгаа гэх тооцоо гарчээ. Тиймээс хүнсний салбарыг дэмжих зайлшгүй шаардлага бий.

Хүн амын 2022-2023 оны хэрэгцээнд зориулж, 15.0 мянган тн мах, 90.0 мянган тн гурил үйлдвэрлэх, зохистой дадлын шаардлага хангасан хүнс боловсруулах, хүнсний сав баглаа боодол үйлдвэрлэх, гол нэрийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, худалдаалах, агуулах зоорийн үйл ажиллагаа эрхлэх хүнсчиддээ зориулж 3%-ийн нэн хөнгөлөлттэй хүүтэй, 2 жилийн хугацаатай 550,0 тэрбум төгрөгийн зээлийг банкны эх үүсвэрээр олгох шийдвэрийг Засгийн газраас гаргасан байна.

Мөн импортын хамаарал өндөртэй цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тосыг гаалийн албан татвараас чөлөөлөх, өвөл, хаврын улиралд үйлдвэрт нийлүүлсэн 19,2 сая литр сүүнд 9.5 тэрбум төгрөгийн урамшуулал олгох асуудлыг шийдээд байна.



**Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх
Улсын мал эмнэлэг, ариун
цэврийн төв лабораторид
ажиллалаа**



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд хүнсний үйлдвэр, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын байгууллага, лабораториудад ажиллалаа.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори нь 1947 онд байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын нутаг дэвсгэр мал амьтны гоц халдварт өвчнийг илрүүлэх, экспорт импортын мал амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдэд ариун цэврийн магадлан шинжилгээ хийж баталгаа гаргах зэрэг чиглэлээр ажилладаг. Мал эрүүл бол хүн эрүүл тул "Хүнсний хувьсгалд энэхүү лабораторийн үр нөлөө их бий. Монгол Улсад шинжлэх ухааны мал эмнэлгийн салбар үүсгэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой тохиож байгаа босгон дээр Ерөнхийлөгч тус салбарт зочилж байгаад нийт малын эмч, эрдэмтэн судлаачид, албан хаагчид талархлаа илэрхийлж байлаа.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори нь шинжилгээнд давхардсан тоогоор 450 гаруй төрлийн багаж тоног төхөөрөмж, 750 гаруй нэрийн оношлуур урвалж бодис, 850 гаруй нэр төрлийн туслах хэрэглэгдэхүүн хэрэглэдэг. Илрүүлэх, оношлох, баталгаажуулах шинжилгээг жилд 40–50 мянган дээжинд улсын төсвийн хөрөнгө, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, аж ахуйн нэгжийн захиалгаар гүйцэтгэдэг юм.

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа тэргүүлэх гурван эрдэм шинжилгээний хүрээлэнд 1,000 гаруй эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж, 10,000 гаруй оюутан суралцдаг. Ерөнхийлөгч дээрх гурван хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцаж,





салбарын төлөөллүүдтэй уулзлаа. Энэ үеэр эрдэмтэн судлаачид өөрсдийн мэддэг чаддаг бүхнээ Хүнсний хувьсгалд зориулахад бэлэн гэдгээ илэрхийлсэн юм. Мөн хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд бусад салбар, тэр дундаа уул уурхайн салбар ч чухал нөлөө үзүүлнэ гэдгийг хэлж байлаа. Монголын нийт ард түмний эрүүл, аюулгүй хүнс хэрэглэх эсэх нь эдгээр эрдэмтэн судлаачдын мэдлэг чадвартай нягт холбоотой.


Үндэсний үйлдвэрүүдийн болон экспорт, импортын бүтээгдэхүүнд хими, хор судлал, нян судлал, гэх мэт био туршилтын шинжилгээг батлагдсан аргачлалын дагуу хийж, хэрэглэгчдийг үнэн зөв шинжилгээний үр дүнгээр хангах зорилготой Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн хүчин чадал, нөөц бололцоотой Ерөнхийлөгч танилцан, тулгамдаж буй бэрхшээлүүдийг нь сонслоо.

Тус лаборатори нь 141 ажилтантай бөгөөд хяналтын байгууллагын хяналт шалгалтын үр дүнг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах үндсэн чиг үүргээс гадна хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, хүнсний шинжилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, лабораториудын ур чадварыг үнэлэх сорилтыг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах чиглэлээр ажиллаж байна.





"Хүнсний хувьсгал" үндэсний үйлдвэрлэгчдийн нурууг тэнийлгэнэ



Монгол Улсын төрийн тэргүүн Ухнаагийн Хүрэлсүх Улс орныхоо тусгаар тогтнол, хөгжил дэвшил, үр хүүхдийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Монголоо гэсэн зүрх сэтгэлтэй хүн бүр "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, хамтран ажиллахын зэрэгцээ эх орондоо үйлдвэрлэсэн хоол хүнс, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авдаг эх оронч хэрэглэгч байхыг ард түмэндээ уриалж байна. Энэ уриалгыг үндэсний үйлдвэрлэгчид алга ташин дэмжлээ. Өөрөөр хэлбэл удаан хугацаанд анхаарлын төвөөс гадуур орхигдсон хүнсний салбарын бугшсан асуудлууд шийдэгдэх боломж бүрдэж байна. Энэ нь хүнс үйлдвэрлэгчид төдийгүй бусад уялдаа холбоотой ажилладаг баялаг бүтээгчдийн нурууг тэнийлгэж буй явдал юм.

Монгол Улсын
Ерөнхийлөгчийн эдийн
засгийн бодлогын
зөвлөх **Б.Даваадалай:**



“Ирэх таван жилд төр, засаг хувийн хэвшилтэйгээ хамтарч ажиллан Хүнсний хувьсгал хийх гэж байна. Энэ хөдөлгөөн зөвхөн хүнсний салбар гэлтгүй бусад салбарт ч үр дүнгээ өгнө”

Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
Үйлдвэр, үйлчилгээ
хариуцсан бодлогын
зөвлөх **Ч.Даваабаяр:**



“Үндэсний үйлдвэрлэгчид бол энэ цаг үеийн баатрууд. Баатруудыг Монгол Улсын Ерөнхийлөгч өөрөө улс төрийн манлайлал гарган дэмжиж байгаа нь анх удаа болж байна”

Монгол Улсын
Ерөнхийлөгчийн Хот,
хөдөөгийн бодлогын
зөвлөх **О.Буяннэмэх:**



“Улс орон болгоны өмнө тулгамдаж байгаа нэг асуудал бий. Энэ бол хүнсний хомсдол. Монгол Улсад ч гэсэн уг асуудал тулгамдаж байна. Бид мах, төмс, гурилаар дотоодын хэрэгцээгээ хангаж байна. Харин бусад хүнсээ хараахан чадаагүй байна. Манай улс жилд нэг тэрбум орчим ам.долларын хүнсийг гаднаас худалдан авч байна”



Монгол Улсад төдийгүй Азид цор ганц үйлдвэр

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх үндэсний үйлдвэрлэгч "АПУ" хувьцаат компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагаатай танилцлаа. Тус компани нь нийт 2,000 гаруй ажилчидтай бөгөөд 11 мянга гаруй харилцагчаараа дамжуулан хэрэглэгчдээ эрүүл аюулгүй, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнээр хангаж байна. Ерөнхийлөгч 40 гаруй нэр төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг "АПУ Дэйри" ХХК-ийн монгол сүүний үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа. Тус компани сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн 30 хувийг хангадаг бөгөөд "Монгол сарлаг" төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тус компанийн үйлдвэр нь хүний оролцоогүй бүрэн автомат, Монгол Улсад төдийгүй Азид цор ганц гэдгээрээ онцлог.



"АПУ" ХК-ийн ТУЗ-ийн дарга **П.Батсайхан**:

“Дэлхий нийтээрээ хариуцлагатай хэрэглээ гэдэг зүйлийг чухалчилж байна. Бид үүний дагуу үйлдвэрлэлээ явуулж байна. Бид хэлэхээс илүү үйлдлээрээ харуулна. Тийм ч учраас архины градусыг 34-36 болгож багасгасан”



"АПУ" ХК-ийн Чанарын ахлах менежер **Ц.Ичинхорлоо**:

“Тариаланчдын нийлүүлсэн улаан буудай, малчны хотноос гарсан сүү харилцагчдаг эцсийн бүтээгдэхүүн болон хүрэх хүртэл үйлдвэрлэлийн бүхий л шат дамжлагадаа бүрэн хяналттай байдаг тул манай бүтээгдэхүүн стандартын шаардлагыг бүрэн хангаж байгаа гэдэгт итгэлтэй байж болно”





“Жүр Үр” компанийн дэд захирал **Б.Мөнхзул**:



Ажил олгогчдыг дэмжсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна”

“Топ 100” аж ахуйн нэгжид үндэсний үйлдвэрлэгч цөөхөн байна

Бялуу, нарийн боов, бейкерийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн “Жүр Үр” компани нь Топ 100 аж ахуйн нэгжийн нэг болсон үндэсний үйлдвэрлэгчдийн төлөөлөл юм. “Жүр Үр” компанийн дэд захирал Б.Мөнхзул “Манай улсад зөвхөн ажилгүй иргэд, малчдыг л дэмжих бодлого яригддаг. Хүнсний хувьсгал төдийгүй бусад салбарын үйл ажиллагааг дэмжихийн тулд ажил олгогчдыг дэмжих хэрэгтэй” гэдгийг онцолж байв.





Техник, технологийн шинэчлэлийг тасралтгүй хийнэ

"Өгөөж-Чихэр боов" ХХК-ийн удирдлагууд "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг дэмжиж буйгаа илэрхийлж, цаг үеэ олсон, үндэсний аюулгүй байдал, монголчуудын эрүүл амьдрахад чухал нөлөө үзүүлэх хөдөлгөөн гэж дүгнэлээ. Мөн энэ хөдөлгөөн амжилттай хэрэгжсэнээр иргэд эрүүл байхаас гадна ажилтай, орлоготой амьдрах нөхцөлийг бүрдүүлэх юм.



"Өгөөж-чихэр боов" ХХК-ийн ерөнхий захирал
С.Түмэнгэрэл:



Эх орондоо үйлдвэрлэл эрхлэх тав тухыг бий болгож өгч байгаа тул манай хамт олон "Хүнсний хувьсгалыг маш их дэмжиж байна. Үйлдвэрлэлийг төр засгийн түвшинг ингэж дэмжиж байсан тохиолдол өмнө нь байгаагүй"





Тариаланчдын хөлс хүч, үйлдвэрлэгчдийн сэтгэл зүтгэл шингэсэн байгалийн, жинхэнэ органик бүхэл үрийн гурил

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, идэвхтэй оролцоно гэдгээ "Хангай Милсс" ХХК-ийн ерөнхий захирал Л.Ганбат илэрхийллээ. "Хурх" гурилын үйлдвэр хоногт 120 тн улаанбуудай боловсруулах хучин чадалтай, хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж бүхий бүрэн автомат үйлдвэр юм.



"Хангай Милсс" ХХК-ийн
ерөнхий захирал Л.Ганбат:



Ерөнхийлөгчийн санаачилсан энэ хөдөлгөөн маш зүйтэй, цаг үеэ олсон гэж бодож байна. Үүнийг ажил хэрэг болгож, дунд шатны байгууллагууд анхаарах хэрэгтэй. Бид өөрсдийгөө айл гэж бодох юм бол хүнсээ өөр айлаас гуйдаг байж болохгүй"





"ГБТ-Трейдинг" ХХК-ийн дэд захирал **Ц.Төгсөө**:



Эргэлтийн хөрөнгө, зээл, татварын бодлогоор дэмжвэл үндэсний аж ахуйн нэгжүүд тогтвортой ажиллах, ажлын байраа хадгалах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх зэрэг давуу талтай. Энэ нь Ерөнхийлөгчийн санаачилсан ирэх таван жилд хүнсний гол нэрийн 19 төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах зорилтыг Биелүүлэхэд дорвитой хувь нэмэр болно”

Баялаг бүтээгчдийн баялаг бол ажиллах хүч юм

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгыг зөвхөн ажил олгогчид л дэмжиж байна гэж ойлговол өрөөсгөл болно. Үндэсний хүнс үйлдвэрлэл явуулдаг 2000 орчим байгууллагын ажилтан албан хаагч ч бас дэмжин, талархаж байгаа юм. Тухайлбал 60 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн "Газар шим" барааны тэмдэгтэйгээр худалдан борлуулдаг "ГБТ-Трейдинг" ХХК-ийн ажилчид Хүнсний хувьсгал орон даяар хэрэгжиж эхэлсэн нь тэдний ажил амьдралд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Ажил олгогч баялаг бүтээгчдийн хувьд ажиллах хүчин нь жинхэнэ баялаг нь байдаг.



"ГБТ-Трейдинг" ХХК-ийн ээлжийн ахлах **Д.Ундармаа**:



Ерөнхийлөгч манай үйлдвэрт ирж, бидний үйл ажиллагаатай танилцсан баяртай байна. Ямар ч үед ажилчдаа ажилтай, орлоготой байлгадаг хүнс үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байдгаараа би үргэлж бахархдаг”





"Чиглэл" ХХК-ийн
захирал Ц.Бумцэнд:



Эрүүл хүнс аюулгүй савлагаанаас эхлэлтэй

Эрүүл аюулгүй хүнсэнд сав баглаа боодол хамгийн чухал нөлөөтэй. Тухайлбал сүүлийн үед иргэдийн ихээр хэрэглэж байгаа цэнхэр, шар хуванцар савуудыг химийн хортой болон аюултай бодис хадгалах, тээвэрлэхэд л нэг удаа ашигладаг. Гэвч бид өдөр тутам хэрэглэсээр байна. Иймд төрийн тэргүүн үндэсний сав баглаа боодлын үйлдвэрлэгчид "Чиглэл" болон "ОБ Пластик" компанид ажиллаж, бодит нөхцөл байдалтай нь танилцлаа. 1990 оноос хойш нийтийн хоолны тоног төхөөрөмжийн засвар угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Чиглэл" компани хоол үйлдвэрлэлийн зориулалтын сав, тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэдэг бол "ОБ Пластик" үйлдвэрийн хувьд 170 орчим ажилтан, 70 орчим машин, тоног төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаа явуулж, гялгар уут, баглаа боодлын зах зээлийн 50–60 хувийг дангаараа хангадаг байна.

Хүнсний хангамж, аюулгүй байдал"-ыг хангахад хүнсний тоног төхөөрөмж, засвар, үйлчилгээний салбар салшгүй нэг хэсэг учир нэгдсэн бодлогоор хангах шаардлагатай. Ижил төрлийн тоног төхөөрөмжид тавих импортын гаалийн татварыг нэмж, дотоодын зах зээлээ хамгаалах нь чухал"



Сав баглаа боодлын салбарынхан:



Тусгай зөвшөөрөл олгохоос эхлээд төрийн хүн суртал их, мөн түүхий эдээ 99 хувь импортоор авдаг учир үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжсэн, хамгаалсан тогтвортой бодлого чухал. Тухайлбал бэлэн бараа бүтээгдэхүүн оруулж ирж худалдахад өнгөр татвар ногдуулж, түүхий эдээ импортоор авч үйлдвэрлэл эрхэлбэл бага татвартай байх нь зүйтэй"





"БОСА Холдинг" ХХК-ийн ерөнхий захирал
Б.Нандинчимэг:



Урт хугацаатай, хүү багатай зээлд хамруулах, 3-5 жилийн хугацаанд татварын хөнгөлөлт үзүүлэх, түүхий эд, тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх нь готоогын үйлдвэрүүдэд томоохон дэмжлэг болно"

Монголд массын чихрийн үйлдвэр ганцхан байдаг

2020 оноос эхлэн чихрийн масс үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор байгуулагдсан "БОСА Кондитер" компанийн "Monkondi" чихрийн үйлдвэр жилд 3,000 тонн хатуу болон шоколадан чихэр үйлдвэрлэх хүчин чадалтай. Өөрөөр хэлбэл Монгол Улсад байгаа цор ганц массын чихэр үйлдвэрлэдэг үйлдвэрлэгч юм.



"MONKONDI" Чихрийн үйлдвэрийн технологи
Б.Нарангарав:



Дэлхийн шилдэг технологиор эх орондоо чихэр үйлдвэрлэж байгаа нь бидний гол давуу тал. Үүнийгээ ашиглаад олон төрлийн чихэр үйлдвэрлэхээр бид төлөвлөж байна"



"Хүнсний хангамж аюулгүй байдал-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологи, инновац" үндэсний зөвлөгөөн боллоо.



2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор "Хүнсний хангамж, аюулгүй байдал-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологи, инновац" үндэсний зөвлөгөөнийг "Корпорэйт конвеншн" центрт зохион байгууллаа.

Энэ зөвлөгөөн бүх салбар, түвшинд шинжлэх ухаан, технологи, инновацийн талаарх ойлголт, мэдлэг, соёлыг түгээх, инновацийн олон талт түншлэлийг өргөжүүлэх, Халамжаас хөдөлмөрт, Олборлолтоос боловсруулалтад, Импортоос экспортод шилжих орон болох зорилтыг хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэх зорилготой юм.

Хүнсний аюулгүй байдал гэдэг нь хүн амьдралынхаа туршид чанартай, шим тэжээлтэй, аюулгүй хүнсийг эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байхыг хэлдэг.


Гэвч манай улсад энэ боломж, нөхцөл алдагдсан гэдгийг мэргэжилтнүүд анхааруулсаар ирсэн.





Боловсрол, шинжлэх ухааны сайд
Л.ЭНХ-АМГАЛАН:

“
Монгол Улсын Ерөнхийлөгч өмнө нь шинжлэх ухаанд хамгийн ээлтэй Ерөнхий сайд байсан, одоо хамгийн ээлтэй Ерөнхийлөгч болж байна. Манай хөгөө аж ахуйн шинжлэх ухааны салбар хамгийн потенциал өндөртэй боловч үүнийг улс орны хэмжээнд бодлого шийдвэр гаргахад бүрэн ашиглаж байгаагүй. Хүнсний хувьсгал үүнийг өөрчлөнө гэж бодож байна”





Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч,
академич **Д.Рэгдэл:**



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх санаачилга гаргаж, эрдэмтэн судлаачдынхаа эрдэм чадлыг эх орныхоо хөгжил дэвшилд ашиглах гэж байгаад нийт оюуны баялаг бүтээгчийнхээ өмнөөс талархаж байна. Нэн тэргүүнд Хүнсний хувьсгал буюу монгол хүний эрүүл мэнд, амь настай холбогдох чухал ажилд хүчээ өргөхдөө бид баяртай байх болно.”

Манай улс жилд нэг тэрбум ам.долларын хүнсний бүтээгдэхүүнийг импортоор авдаг нь эдийн засаг, цаашлаад иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг.

Ялангуяа сүүлийн үед бага насны хүүхдүүд хорт хавдраар өвчилж байгаа нь хүнсний аюулгүй байдалтай шууд холбоотой гэж эрдэмтэд үзжээ. Иймд Ерөнхийлөгч Хүнсний хувьсгалыг санаачлан орон даяар хэрэгжүүлж байгааг дээрх салбарынхан болон баялаг бүтээгчид талархан хүлээн авч байна.

Тэд:

- Малаа эрүүлжүүлэх, идэш тэжээл, хөрсний бордоо зэрэгт анхаарах
- Мэргэжилтэй ажиллах хүч, судлаачдыг тасралтгүй бэлтгэх, ажиллах боломжоор хангах
- Монгол хүний судалгаа, өгөгдлийн сан бий болгох
- Хүнс үйлдвэрлэх, боловсруулах бүх шатанд хянатын тогтолцоог сайжруулах зэрэг санал дэвшүүлж байлаа.



Булган аймаг Хишиг-Өндөр сумын
хүнс үйлдвэрлэгч **М.Зоригт**



Орон нутгаа төлөөлж ирсэн хүний хувьд Ерөнхийлөгчийн санаачилгыг дэмжиж байгаагаа хэлье. Орон нутгийн үйлдвэрлэгчдээ сайн дэмжээсэй гэж хүсэж байна. Би өөрийн амьдардаг болон тойргийн сумдын өндөгний хэрэгцээг хангахад хувь нэмрээ оруулж байгаа. Цаашид илүү их хөдөлмөрлөх болно.”

"Монпеллетс" ХХК-ийн ерөнхий захирал **Б.Цогбадрах**:



Хүнсний хувьсгал өрнөж байгаад маш их талархаж байна. Манай компани хонины ноосоор бордоо хийж, экспортог гаргадаг. Хүнс эрүүл байхын тулд хөрс эрүүл байх хэрэгтэй. Энэ хөдөлгөөн манай салбарт том дэмжлэг болно."



ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн захирал **Ж.Туяацэцэг**:



Хүн амын хоол тэжээл болон хүнсний аюулгүй байдлын талаар хийсэн судалгаа их бий. Үүний нэг нь Нийгмийн эрүүл мэндийн байгууллагууд хийсэн таван шатны судалгаа юм. Судалгаануудын үр дүнгээс харахад монгол хүний эрүүл мэнд улам бүр дордож байна. Ялангуяа халдварын бус өвчлөл манайд ихсэж байгаа бөгөөд 10 хүртэл хүн тутмын 1 нь ямар нэг халдварын бус өвчтэй гэсэн судалгаа гарчээ."





Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд үндэсний үйлдвэрлэгч "Очирдагинас" ХХК, "Витафит Инвест" ХХК-д ажиллалаа.



"Витафит Инвест" ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Жаргалсайхан:



Хүнсний хувьсгалын хүрээнд бид үйл ажиллагаагаа өргөтгөж, энэ хэрээр олон ажлын байр бий болгохоор төлөвлөсөн"



"Витафит инвест" ХХК судалгаанд суурилж бүтээсэн, аминдэмээр баялаг "Монгол лууван" жүүсийг үйлдвэрлэж байна

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх "Витафит Инвест" ХХК-д ажиллалаа. Тус компани 13 брэндийн 120 гаруй төрлийн жүүс үйлдвэрлэн, зах зээлийн 45 хувийг дангаар хангадаг юм.

Манай улсын хувьд бага насны хүүхдийн дунд бичил шимт бодисын дутагдал их, хүн амын 50 хувь нь өдөр тутмын аминдэмийн хэрэгцээгээ хангахуйц шим тэжээлтэй хоол хүнс худалдан авах чадвар бага зэрэг шийдвэрлэх ёстой асуудал бий.





ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

"ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



"Витафит милк" ХХК-ний
үйлдвэрлэл эрхэлсэн
дэд захирал, доктор
Ч.Нарангэрэл:



Сүү бол маш гайхалтай бүтээгдэхүүн. Манай компани аль болох хэрэглэгчидгээ эрүүл, аминдэмтэй бүтээгдэхүүн хүргэхийг зорьдог. Хүнсний хувьсгал хэрэгжсэнээр илүү өргөн цар хүрээнд ажиллах ёстой боллоо"

Тэгвэл тус компани "Монгол лууван" төслийн хүрээнд Гоё, Бумбардай, Маази, Монгол лууван гэх дөрвөн брэндийн 12 бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээс 3-4 дахин хямдаар хэрэглэгчдэд нийлүүлж байна.



"Витафит групп" ХХК-ийн
зөвлөх **С.Содном:**



Манай хүнс үйлдвэрлэгчдэд шинэ технологи, мэдлэг чадвартай боловсон хүчин маш их хэрэгтэй байна. Монгол Улсын Ерөнхийлөгч чухал санаачилга гарган үндэсний үйлдвэрүүдэд ажиллаж байгаад ахмад ажилтны хувьд баярлаж байна"



Маркетингийн газрын
дарга **Б.Сайнбилэг:**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан үндэсний хөдөлгөөний гол амин сүнс нь дотооддоо эрүүл хүнс үйлдвэрлэх юм. Энэ зорилгод аминдэмээр баялаг Naval F1 сортын луувангийн жүүснүүд онцгой үүрэг гүйцэтгэнэ"



"Витафит милк" ХХК-ийн
хуульч **Ц.Алтансүвд:**



Ерөнхийлөгчийн санаачилсан үндэсний хөдөлгөөний хүрээнд хууль, эрхзүйн орчинд олон таатай өөрчлөлт гарч байгаа юм билээ. Угаан хугацаанд орхигдоог байсан хүнсний салбарт төр анхаарал хандуулж байгаад хүнс үйлдвэрлэгчид их баяртай байгаа"



ОЧИРДАГИНАС
OCHIRDAGINAS

ТОВЧ ТҮҮХ

2005 он	2007 он	2009 он	2012 он	2016 он
"Очирдагинас" ХХК нь 2005 онд байгуулагдсан ба хивам, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 17 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.	"Очирдагинас" ХХК нь 2007 онд хивам, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн урсгал технологийг нийцсэн өөрийн үйлдвэрийг ашиглалтанд оруулсан.	Герман технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлж герман мюж амтлагны үйлдвэрлэгч MOGUNTIA компанитай хамтарч ажиллах болсон.	ХБНГУ-ын Kuhlmann компанитай түршлага солилцоо ажилтан бэлтгэх тал дээр хамтра ажиллаж эхэлсэн.	Хүнсний хувьсгал

Гадны өндөр шаардлагад нийцсэн, мах, махан бүтээгдэхүүн экспортлож байна

2005 оноос хойш мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж буй "Очирдагинас" ХХК компани ISO 22000:2018 шинэ стандартыг Монголд анх удаа "Экспорт үйлдвэр"-тээ нэвтрүүлжээ.

Үйлдвэрийн гол түүхий эд болох махыг өөрийн гэрээт бэлтгэн нийлүүлэгчид болон малчдаас гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлэгийн эрүүл ахуйн бичигтэй хүлээж аван, шинжилгээ хийж баталгаажуулсны дараа хэрэглэж байна.

Түүхий эд материалаа хүлээж авах, хадгалахаас эхлээд хэрэглэгчдийн гарт очих хүртэл бүх шатанд маш өндөр хяналт тавьдаг.

"Очирдагинас" ХХК-ийн гүйцэтгэх захирал
Х.Тэмүүжин:



Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг бүрэн дэмжиж, бусдыгаа манлайлан оролцоно. Бидний зорилго бол бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд нэвтрүүлж, үндэстэн дамнасан корпораци байгуулах явдал юм"

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

"ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



ХХААХҮ-ийн дэд сайд
Г.Батсуурь:

“
Манай салбарын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамгийн их харцуцлагатай байх ёстой. Учир нь монгол хүний эрүүл мэнд цаашлаад улс орны аюулгүй байдалд чухал хувь нэмрээ оруулж байна. Иймд энэ хүмүүсээ бодлогоор дэмжих хэрэгтэй”

50 гаруй нэр төрлийн чанамал, хагас утлагат, давхар утлагат хиам, элэгний нухаш, зайдас, утсан мах, Баян Монгол, Bio брэндийн нөөшилсөн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлдэг.

Өдөрт 10,500–14,500 кг хиам, махан бүтээгдэхүүн, 3,200 кг нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай, 500 тн-ын хөргөлтийн зоорьтой юм.



"Очирдагинас" ХХК-ийн Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга **Ж.АЙБЕК:**

“
Манай үйлдвэр эрчим хүчний хэрэглээгээ өөрсдөө шийдвэрлэсэн нь их том давуу тал болж байна. Цаашид энэ мэт шинэлэг бөгөөд дэвшилтэт санаачлагуудыг байнга хэрэгжүүлж, бусдыгаа манлайлан ажиллана”





УИХ-ын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга **Б.Чойжилсүрэн:**



Сүүлийн үед хүн бүр органик бүтээгдэхүүн хэрэглэх хүсэлтэй болж байна. Манай хүнсний бүтээгдэхүүн дэлхийд тэргүүлэх нөөц бололцоо их байгаа ч үүнийгээ нотлож, таниулах, техник, технологийн шинэчлэлт хийх, санхүүгийн асуудлаа шийдвэрлэх зэргээс болж гадагшаа гарч чадахгүй байна”

“Очирдагинас” ХХК нь 2009 онд үйлдвэрийн технологидоо шинэчлэлт хийж Герман технологиор бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж эхэлсэн байна. Ингэснээр бүтээгдэхүүний амт чанар сайжирч, Европын Холбооны Улсуудад хэрэглэж буй орчин үеийн шинэ технологийг эх орондоо нутагшуулах, тэдэнтэй хөл нийлүүлэн алхах боломжтой болжээ.

ХБНГУ-ын Франкфурт хотод гурван жилд нэг удаа зохион байгуулдаг Мах, махан бүтээгдэхүүний техник, технологи, чанар стандартын “IFFA-2016” олон улсын үзэсгэлэнд таван бүтээгдэхүүнээр оролцож нэг алт, гурван мөнгө, нэг хүрэл медаль хүртсэн байна.



Эдийн засаг, хөгжлийн дэд сайд **С.Наранцогт:**



Хүнсний хувьсгал хэрэгжсэнээр хүний эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлээд зогсохгүй, хүнс үйлдвэрлэгч болон бусад хамааралтай үндэсний брэнд сэргэж, ажлын байр ч нэмэгдэнэ”



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээ хариуцсан бодлогын зөвлөх бөгөөд Хүнсний төсөл, хөтөлбөр хариуцсан албаны дарга **Ч.Даваабаяр**:

Аливаа улс үндэстний аюулгүй байдлын үндэс нь найдвартай баталгаатай хүнсэн дээр тогтдог. Манай улс жилд нэг тэрбум ам.долларын хүнсний бүтээгдэхүүнийг импортоор авч байна. Үүнийг багасгаж нэн тэргүүнд дотоодын үйлдвэрлэлээ дэмжиж, эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ард түмнээ эрүүл хүнсээр хангах шаардлагатай. Энэ шаардлагыг Монгол Улсын Ерөнхийлөгч харж ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ-ыг санаачлан эхлүүлсэнд талархаж байна.

Түүнчлэн МХЕГ, татварынхан хянадаг, шалгадаг, торгодог байдлаа үндсээр нь халж зөвлөн тусладаг болсонд үйлдвэрлэгчид ам сайтай байна.

Ерөнхийлөгчийн санаачлагыг УИХ дэмжин хууль эрх зүйн орчныг бүрдүүлж 1,7 их наяд төгрөгийн төсвийг баталж өгсөн нь иргэдээ бодсон ТҮҮХЭН ШИЙДВЭР байлаа. Энэ шийдвэрийг ажил хэрэг болгон ирэх таван жилд 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээ дотоодоосоо 100 хувь хангахад төр засаг, баялаг бүтээгчид, үндэсний үйлдвэрлэгчид болон ард түмний идэвх, оролцоо маш чухал байгааг онцлон хэлье.

Цаашид бид ижил төстэй импортын бүтээгдэхүүний татварыг үе шаттайгаар нэмэгдүүлж дотоодын зах зээлээ хамгаалах зорилт тавин ажиллах болно. Мөн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх, эх оронч худалдан авалтыг дэмжих шаардлагатай. Төр томоохон худалдан авагч болох суурь ч тавигдаж байна. Мөн бага хүүтэй, урт хугацаатай зээл олгох нь зүйтэй. Эдгээрийг баялаг бүтээгчид олон жилийн турш хүсэж, ярьж байгаа. Харин одоо биелэлээ олоход тун ойрхон ирлээ.

Монгол Улсад газар тариалан, мал аж ахуй, үндэсний үйлдвэрлэл хөгжих суурь тавигдлаа. Дундардаг бус үрждэг баялаг бий болгохын төлөө баялаг бүтээгч та бид хичээх л үлдлээ.

Баялаг бүтээж эх орондоо сайхан амьдарцгаая.




"Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталлаа



ХХААХҮ-ийн сайд **З.Мэндсайхан:**



Таван жилийн хугацаанд мал сүргээ бүрэн дархлаажуулах 145 тэрбум төгрөг хэрэгтэй. Бид жилд хоёр удаа вакцинжуулалт хийхээр төлөвлөсөн. Хоршооллын хувьд өрхийн аж ахуйг дэмжихэд нийт найман тэрбум төгрөг хөтөлбөрт суусан”



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталлаа.

Ерөнхийлөгч хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр шинжлэх ухаанд суурилсан нэгдсэн бодлогыг бүх шатанд, хамтын хүчээр хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэн тогтоолын төсөл санаачилсан юм.

Тогтоол батлагдсанаар хууль эрх зүйн орчныг сайжруулах, урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчингүй эрүүл бүс

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

"ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН



болох, ирэх таван жилд хүнсний гол нэрийн 19 төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, улмаар бүс нутагт хүнс экспортлогч орон болох зорилтыг хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

Тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийг жил бүрийн улсын төсөв, олон улсын зээл, тусламж, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт зэргээс бүрдүүлэх юм.



Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга **Д.Болорчулуун**:

“Манай улс хүнсний хангамж, аюулгүй байдлаараа гаднаас хараат байгааг хүн бүр мэднэ. Тиймээс үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж, хүнсний аюулгүй байдлаа хангаж ажиллая гэж тогтоолын төслийг Ерөнхийлөгч өргөн мэдүүлсэн. Энэ хүрээнд холбогдох байнгын хороо, салбар, яам ажилласан. Монгол Улс нэн тэргүүнд 19 нэр төрлийн гол нэрийн хүнсээ дотоогоо бүрэн хангах бодлого дэвшүүлсэн. Энэ хүрээнд гаалийн татвар таван хувь байгааг 20,30 гаруй хувь өсгөхөөр төлөвлөж байна”



УИХ-ын гишүүн **С.Бямбаогт**:

“Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаарх тогтоолыг хэрэгжүүлэхдээ бусад хуультай уялдуулах нь зүйтэй”





УИХ-ын гишүүн **Ж.Бат-Эрдэнэ**:



Ерөнхийлөгчийн оруулж ирж байгаа тогтоолтой санал нэг байгаа. Монгол Улсын эдийн засгийг өргөх гол суурь болсон жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүнсний хангамжийг сайжруулах тал дээр “хувьсгал” хийх маш том бодлого гэж харж байна”



УИХ-ын гишүүн **С.Одонтуяа**:



Хүний эрүүл мэндэд хортой бодисыг хүнс үйлдвэрлэлд хэрэглэсэн бол Эрүүгийн тухай хуулиар ялладаг болох ёстой”



УИХ-ын гишүүн **Ц.Туваан**:



Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх ганц хөшүүрэг бол урамшууллын бодлого”



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 36

Төрийн ордон, Улаанбаатар хот

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2."Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:

а/хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, цаашид экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай нийт 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 онд улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, шаардлагатай бол хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

б/энэ тогтоолын хавсралтад заасан хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит болон 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

в/тарифын зохицуулалт хийх замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2022 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

г/хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгох асуудлаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

д/хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж батлуулах, хүнсний чиглэлийн бүх стандартад дүн шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай стандарт, техникийн зохицуулалт, хүнсний сүлжээний үе шат бүрд зохистой дадлын зөвлөмж, зааврыг шинэчилж, шинээр батлах;

е/мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх;

ж/хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон журмыг боловсруулан батлах;

з/хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох, пестицид, малын эм, хоруу чанар өндөртэй нян, хүнд металлын үлдэгдлийг хянах, хяналтын төлөвлөгөөг батлах;

и/хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, нөөцийн нэгдсэн тогтолцоо, түүний удирдлагын системийг бий болгож, логистик нийлүүлэлтийн төвүүдийг үе шаттайгаар байгуулах, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

к/хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын татаас, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож, шаардлагатай урамшууллын хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт бүрэн тусгаж, хэрэгжүүлж байх.

2/Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

а/"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг урт хугацаатай, хүү багатай эх үүсвэрээс санхүүжүүлэх, улсын болон орон нутгийн төсөв, бусад санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулан төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоонд тулгуурлан зохион байгуулах;

б/"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг Засгийн газраас батлан улс орон даяар "Эх орны эрүүл хүнс" уриан доор хэрэгжүүлж байгаа "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-тай уялдуулан хэрэгжүүлэх;

в/хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

г/мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг мөрдүүлэх, хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх;

д/хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн явцад аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасан эсэхэд тавигдах дотоодын хяналтыг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх;

е/хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн төрийн өмчит их, дээд сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, сургалтын чанарыг сайжруулах, эдгээр салбарт тэргүүлэх чиглэлээр суралцагчид сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, мэргэшсэн ажилтны ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах;

ж/хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, эрчим хүч, уур, дулааны эх үүсвэр, шатахуунаар тогтвортой хангах;

з/монгол орны байгаль, газар зүй, цаг уурын онцлогтой уялдсан уламжлалт хүнс бэлтгэх арга технологийг сэргээн таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх, хүнс бэлтгэх уламжлалт мэдлэгт суурилсан, инновац шингэсэн бүтээгдэхүүн бий болгох тогтолцоог бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх;

и/хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах хүрээнд мал аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуй эрхлэхээр нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуйн нэгжид татварын болон бусад дэмжлэг үзүүлэх;

к/Монгол Улсад үйлдвэрлэсэн брэнд бүтээгдэхүүнийг олон улсын болон бүс нутгийн хэмжээний үзэсгэлэн худалдаанд танилцуулах, сурталчлах боломжийг бүрдүүлж, экспортлох эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх;

л/хүнс, хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний хүрээлэнгээр захиалгат судалгаа, туршилтын ажил хийлгэх хөрөнгийг нэмэгдүүлэх.

3/Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр:

а/тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган гектар хүртэл атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, эргэлтийн талбайг 1.1 сая гектарт хүргэх, усалгаатай тариалангийн талбайг 5000 гектараар нэмэгдүүлэх, тариалангийн газрыг улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах;

б/ургамлын генетик нөөцийн ашиглалт, хамгаалалт, нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ болон ашигт таримлын үр үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх, Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн үйл ажиллагаанд тулгуурлан улсын хэмжээнд улаан буудайн 4, тэжээлийн 2, хүнсний ногооны 5, төмсний 4, нийт 15 үрийн аж ахуйг байгуулах, сорт сорилтын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлэх;

в/“Монгол Улсад газар тариалан эрхлэх систем” технологийн баримт бичгийг мөрдлөг болгож, хөрсний доройтлыг бууруулах, үржил шимийг хамгаалах, сайжруулах, зохистой ээлжлэн тариалалт бүхий дэвшилтэт технологи нэвтрүүлэх, түүнд нийцсэн техник, технологийн шинэчлэл хийх;

г/тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуйд шаардагдах дотоодын хэрэгцээт тэжээлийн хангамжийг 1.9 сая тоннд хүргэхэд зохион байгуулалт болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

д/хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг 270 гектар хүртэл нэмэгдүүлэн хөгжүүлж, хүн амыг жилийн туршид шинэ ургацын ногоогоор тогтвортой хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, дулааны хангамж, дэд бүтэц бүхий бүс нутгуудад 50 гектар өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах;

е/хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар импортыг орлох, экспортыг дэмжих чиглэлээр уул уурхайн үйлдвэрийг түшиглэн азот, фосфорын бордооны үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжилтийг хангах;

ж/бүх төрлийн будаа, чихрийн манжин, бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэхэд анхаарч, шаардлагатай санхүүжилт, зээл олголтын оновчтой тогтолцоог бий болгох, бодлогын дэмжлэг үзүүлэх;

з/стандартын шаардлага хангасан үр тарианы элеваторын багтаамжийг 20.0 мянган тонноор, төмс, хүнсний ногоог хадгалах механикжсан агуулах, зоорины багтаамжийг 50.0 мянган тонноор тус тус бүсчилсэн байдлаар нэмэгдүүлэх;

и/байгаль цаг уурын эрсдэлийг даван туулах зорилгоор экологид ээлтэй, усыг зөв зохистой ашиглах усалгааны дэвшилтэт технологи нэвтрүүлэх, услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах, шинэчлэх, усан сан бүхий ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, дэмжлэг үзүүлэх;

к/үйлдвэр, фермер, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн үйл ажиллагааг дэмжсэн кластерыг бий болгоход чиглэсэн хөдөө аж ахуйн агро парк байгуулах;

л/“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хүрээнд аймгийн төвд 30 гектар, сумын төвд 10 гектар агро ойн аж ахуйг тус тус байгуулах, жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төв, цэцэрлэгийн аж ахуйг хөгжүүлэх, тариалангийн талбайг хашаажуулж ойн зурвас байгуулах;

м/жил бүрийн намрын ургацаас стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор 100.0 мянгаас доошгүй тонн хүнсний улаан буудайг худалдан авах нөөц бүрдүүлэх.

4/Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр:

а/бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойн зохистой харьцааг бий болгох, малын эрүүл мэндийг хамгаалах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, малыг чанаржуулах, малчдын үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй хамтран ажиллах;

б/мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэн нийлүүлэлт, анхан шатны боловсруулалт, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, загвар хоршоог байгуулах, шинэчлэх, хоршоолох хөдөлгөөнийг бүх талаар дэмжих;

в/хот, суурин газрын ойролцоо, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, махны чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой, сүүний чиглэлийн үүлдрийн 50.0 мянган толгой үхрийн аж ахуй, махны болон нарийн ноост хонины үржлийн цөм сүргийн аж ахуйг бий болгох, өндөр ашиг шимт малын үр хөврөлийг гадаад улсаас нэгдсэн бодлогоор авах, үржил селекцийн ажилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, холбогдох санхүүжилтийг төсөвт тусгах;

г/гахай, тахианы болон өсвөр хонь, үхэр бордох аж ахуйг өргөтгөх, шинээр байгуулахад аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, урт хугацаатай хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

д/зөгийн аж ахуйг хоршоолсон хэлбэрээр хөгжүүлэх, түүний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортлох боломжийг бүрдүүлэх;

е/мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, био бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэх, вакцины хүйтэн хэлхээний сүлжээг бий болгох, оношилгооны лабораторийг чадавхжуулах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлэх, шаардагдах санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах.

5/Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр:

а/мал аж ахуй, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, дотоодын зах зээлд борлуулсан чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгож байгаа урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох;

б/хүүхдийн хоол, сүү, ногоо, жимс, жимсгэнийн тэжээлийн үйлдвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, үндсэн түүхий эдийг дотоодоос бэлтгэн нийлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

в/цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, дотуур байрны суралцагчийн хоолны зардлыг шим тэжээл, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоог хангах;

г/хуурай сүү, хүнсний давс, хүнсний тос, төмс, төрөл бүрийн будаа, элсэн чихрийн боловсруулах үйлдвэрийг шинээр байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

д/хүнсний зориулалтын тусгай тээврийн хэрэгслээр /автомашин, вагон, онгоц/ тоноглогдсон тээврийн паркийг шинээр бий болгох, дотоодын болон экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тогтолцоог бүрдүүлэх;

е/хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, хатаах, хөлдөөх, нөөшлөх бага, дунд оврын тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг дэмжих, хүнсний сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

ж/хүнсний боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар бүтээгдэхүүний амт чанар, сав, баглаа боодлыг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэн экспортын зориулалтын брэндийг хөгжүүлэх, үйлдвэрийн үйл ажиллагааг нь тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих;

з/хүнсний нэмэлт, биологийн идэвхт хүнсний бүтээгдэхүүн, зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийг дэмжих;

и/улсын хэмжээнд лабораторийн шинжилгээний аргачлалыг шинэчлэх замаар хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлох, экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх лабораторийн шинжилгээ, хяналт шалгалтыг хийх тогтолцоог бүрдүүлэх, хилийн болон улсын итгэмжлэгдсэн лабораторийг чадавжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

к/хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.

3.Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусган хэрэгжүүлж, хэрэгжилт, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Х.Болорчулуун/, Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Б.Чойжилсүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА



Г.ЗАНДАНШАТАР

Дэд ажлын хэсгийн гишүүд



Монгол Улсын
Ерөнхийлөгчийн Тамгын
газрын дарга Я.Содбаатар



ХХААХҮ-ийн сайд
З.Мэндсайхан



Монгол улсын
ерөнхийлөгчийн эдийн
засгийн бодлогын зөвлөх
Б.Даваадалай



Монгол Улсын
Ерөнхийлөгчийн Үйлдвэрлэл
үйлчилгээ хариуцсан
бодлогын зөвлөх бөгөөд
Хүнсний төсөл, хөтөлбөр
хариуцсан албаны дарга
Ч.Даваабаяр



Монгол Улсын
Ерөнхийлөгчийн Хот,
хөдөөгийн хөгжлийн
бодлогын зөвлөх
О.Буяаннэмэх



Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн
үйлдвэрийн яамны төрийн
нарийн бичгийн дарга
Т.Жамбалцэрэн



Эдийн засаг, хөгжлийн дэд
сайд С.Наранцогт



ҮАБЗ-ийн Ажлын албаны
хэлтсийн дарга Д.Энхмаа



МХЕГ-ын дарга
Б.Баасандорж



Стандарт, хэмжил зүйн газрын
дарга Б.Билгүүн



ХХААХҮ-ийн яамны Бодлого,
төлөвлөлтийн газрын дарга
Ц.Болорчулуун



Монгол Улсын Ерөнхийлөгчийн
Тамгын газрын Хуулийн
бодлогын газрын ахлах
референт Г.Сувдаа



ХХААХҮЯ-ны Бодлого,
төлөвлөлтийн газрын
Салбарын эдийн засгийн
судалгаа, дүн шинжилгээ
хариуцсан мэргэжилтэн
Ц.Амгалан



“

Ухнаагийн
ХҮРЭЛСҮХ:

УӨРС
ҮНС
ҮН ГУРАВ
ҮЙН ХОЛБООТОЙ

Эрццл хүнс

Эрццл монгол хүн



WWW.HUNSNIIHUVISGAL.MN




ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ



ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

*Баялаг бүтээж эх орондоо
сайхан амьдаруугаая.*



"ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ" сэтгүүлийн редакц

Редактор Б.Сэржмядаг
Л.Итгэлтөгс


Сэтгүүлч Б.Урантуяа
Б.Хулан

Эмхэтгэсэн Г.Лхагвадулам

Эх бэлтгэгч Б.Эрдэнэбилэг
Ш.Баасанжав

Гэрэл зурагчин Г.Ган-Өлзий
Н.Батмөнх
А.Адъяажав

Улаанбаатар хот – 2022 оны 6 сар



QR уншуулж нэгдсэн видео
сангаас мэдээлэл аваарай.